

АГУУЛГА

1. Статистик мэдээ
2. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны үзүүлэлт, үр дүн, хүрсэн түвшин
3. Иргэдэд ээлтэй эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлсэн байдал
4. Дүүргийн төр захиргааны байгууллагатай хамтран ажиллаж эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын биелэлт
5. Байгууллагын удирдлагын манлайлал, нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлсэн байдал
6. Санхүүгийн зөрчилгүй, төсвийн өр авлагын талаарх мэдээлэл
7. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, тайлан мэдээний чанар, хугацаа
8. Дүүрэг болон байгууллага орчноо тохижуулах чиглэлээр хийсэн ажил
9. Ажилтнуудын ажиллах орчин нөхцөл, нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал
10. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн
11. Үйл ажиллагаагаа иргэд, даатгуулагчдад сурталчилсан байдал, зохион байгуулсан сургалт сурталчилгаа, үр дүн

БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2025 оны 06 дугаар сарын 13

Багануур дүүрэг

ЭХЛЭЛ

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар нь тайлант хугацаанд шинээр мөрдөгдөж буй Нийгмийн даатгалын багц хууль, бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газар, нийслэл, дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтод тусгагдсан Нийгмийн даатгалын тухай хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон төрийн захиргааны удирдах дээд шатны байгууллагуудаас гаргасан тушаал, захирамж, тогтоол, шийдвэр, албан даалгаврыг биелүүлж, хэрэгжилтийг ханган ажиллав.


Тайлант хугацаанд ажил олгогч даатгуулагчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэн хамгаалж, хууль дээдлэн, бусдын нөлөөнд үл автан ажиллах зарчмыг баримтлан, дүүргийн нутаг дэвсгэрт нийгмийн даатгалын хуулийг хэрэгжүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх, сангийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг зохих сангаас, хуулиар тогтоосон цаг хугацаанд тогтоон, Sicos цахим системээр бүртгэж олголоо.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/38 дугаар тушаалаар тайлант оныг “Даатгуулагчийг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил” болгон зарласны дагуу шимтгэлийн өр авлагыг бууруулах чиглэлээр анхааран ажиллаж байна.

Тайлант онд өмнөх жилийн санхүүгийн жилийн тайланг шинэ цахим систем, Sicos програмаар гаргах, цахим системийн хөгжүүлэлт, сайжруулалт хийх, их ажлын жил болж байна.

НЭГ. СТАТИСТИК МЭДЭЭ

(2025.05.31-ний өдрийн байдлаар)



ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТ, ҮР ДҮН, ХҮРСЭН ТҮВШИН

Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт, санхүүгийн үзүүлэлтийн талаар

2025 оны 05 дугаар сарын 31-ний байдлаар 15,669,512.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгээс 16,642.642,58 мянга төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 106.2%-иар биелүүлэв. /ЭМД санд 2.539.114,32 мянга төгрөг төвлөрүүлсэн./

Хүснэгт №1

Орлогыг сан тус бүрээр харуулбал:

Сан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Тэтгэвэр	13,070,232.60	11,441,499.61	88,0
Тэтгэмж	1,141,980.90	1,209,357.33	105,8
Эрүүл мэнд		2.539.114,32	
ҮОМШӨ	1,020,950.40	1,025,899.97	100,4
Ажилгүйдэл	436,348.30	426,771.35	98,0

мян.төг-өөр

Орлого, шимтгэл, хамралтын талаар

2025 онд шинээр хамруулах ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо баталсан төлөвлөгөөгөөр ажил олгогч 18, албан журмын даатгуулагч 108 гэж баталснаас 2025 оны тайлант хугацаанд 10 ажил олгогч, 57 даатгуулагчийг шинээр хамруулсан байна. Төлөвлөгөөний биелэлт ажил олгогч 111,1 хувь, албан журмын даатгуулагч 105.5 хувийн гүйцэтгэлтэй байна.



Ажил олгогчийн
Тоо - 353



Албан журмын
даатгуулагчийн
тоо - 7146



Сайн дурын
даатгуулагчийн
тоо - 999

2025 эхний хагас жилийн байдлаар Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангаар 173 байгууллагын 6114,7 сая төгрөгийн авлага, 53 байгууллагын 26.4 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна. Нийт авлагын насжилтаар ангилбал :

- | | |
|----------------------|-------------------|
| 1. 0-30 хоногтой | 2620,8 сая төгрөг |
| 2. 31-90 хоногтой | 1450,9 сая төгрөг |
| 3. 91-180 хоногтой | 813,6 сая төгрөг |
| 4. 181-270 хоногтой | 665,7 сая төгрөг |
| 5. 271-365 хоногтой | 352,1 сая төгрөг |
| 6. 366-730 хоногтой | 292,0 сая төгрөг |
| 7. 731-1095 хоногтой | 6,8 сая төгрөг |

8. 1826 дээш хоногтой 74,5 сая төгрөг байна.

Багануур дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн шимтгэлийн өр 2218.6 сая төгрөг ба нийт авлагын 36,2 хувийг эзэлж байгаа бөгөөд 271-365 хоногийн насжилттай байна.

Багануур ХК 1501,7 сая төгрөгийн шимтгэлийн өртэй бөгөөд авлагын 24,5 хувийг эзэлж байгаа ч 0-30 хоногийн насжилттай. Эдгээр 2 аж ахуйн нэгж байгууллагын авлага нийт 3720,3 сая төгрөг байгаа нь нийт авлагын 60,8 хувийг эзэлж байна.

2025 оныг “Даатгуулагчийг дэмжих, нийгмийн даатгалын өр барагдуулах” жил болгон зарласантай холбогдуулан, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/47 дугаар тушаалын хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг 2025 оны 03 дугаар сарын 03-ны өдөр гарган газрын даргаар батлуулан ажиллаж байна.


Нийгмийн даатгалын шимтгэлийн 50,0 саяас дээш төгрөгийн өртэй 8 ажил олгогчийн нийт 1737,6 сая төгрөгийн авлагатай байна. Эдгээр нь нийт авлагын 28,4 хувийг эзэлж байна.

Үүнд:

- | | |
|-------------------------|------------------------------------|
| 1. Дулааны станц | - 554,5 сая төгрөг /91-180 хоног/ |
| 2. Соёолон групп | - 377,8 сая төгрөг /366-730 хоног/ |
| 3. Мон цахим ХХК | - 233.9 сая төгрөг /366-730/ |
| 4. Боловсрол цогцолбор | - 285.2 сая төгрөг /31-90 хоног/ |
| 5. Гүн галуут цогцолбор | - 114.3,0 сая төгрөг /31-90 хоног/ |
| 6. МИМС ХХК | - 59,9 сая төгрөг /0-30 хоног/ |
| 7. Месес ХХК | - 57,5 сая төгрөг /0-30 хоног/ |
| 8. БНЦМУ ХХК | - 54,5 сая төгрөгийн өртэй байна. |

Бусад 156 ажил олгогч 657,4 сая төгрөгийн өртэй байгаа нь нийт авлагын 10,9 %-ийг эзэлж байна.

Нийт авлагыг графикаар харуулбал:



Тайлант хугацаанд 2024 оны жилийн эцсийн 84 байгууллагын 2,994.2 сая төгрөгийн авлагаас 75 байгууллагын 1,186.9 сая төгрөгийг барагдуулж авлагыг 60,4 хувиар бууруулсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд өмнөх онуудад шилжүүлсэн өр төлбөрөөс оны эхний нэг ажил олгогч буюу МИМС ХХК-ийн 61.8 сая төгрөгийн үлдэгдлээс тайлант

хугацаанд 2,0 сая төгрөгийг барагдуулж 59,9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тус компани шийдвэр гүйцэтгэлийн шатанд сар бүр тогтмол төлөлтөөр төлбөр хийж байгаа болно.

Тус дүүргийн Эрүүл мэндийн төвийн шимтгэлийн өр төлбөрийг барагдуулахаар өр барагдуулах гэрээ байгуулсан боловч санхүүжилт хүрэлцэхгүйн улмаас шимтгэл гэрээний дүнгийн дагуу төлөгдөхгүй, сар бүр батлагдсан төсвийн хуваарилагдсан дүн 80,0 сая төгрөгөөр өр төлбөрийг барагдуулж байна.

Тайлант хугацаанд 1343,5 сая төгрөгийн хуримтлагдсан өртэй 5 ажил олгогчийн дансыг хааж 1333,9 сая төгрөгийг, 5 байгууллагын 73,7 сая төгрөгийг төлүүлэхээр мэдэгдэл өгсөнөөр 65,6 сая төгрөгийг, 3 байгууллагын 1748,3 сая төгрөгийг төлүүлэхээр гэрээ байгуулж 571,6 сая төгрөгийг тус тус төлүүлэв. Нийт 6 байгууллагын 1048,9 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар шүүхэд шилжүүлэн ажиллаж байна.

Программын мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн талаар

2025 оны 01 дүгэр сараас шинээр нэвтрүүлж буй Sicos ситемээр шимтгэлийн тайланг хүлээн авч ажиллаж хэвшсэн боловч зарим тохиолдолд шалгасан тайлангууд тайлан хүлээн авах хугацаа болсон байхад баталгаажсан төлөвт шилжихгүйн улмаас ажил олгогчийг дахин тайлан илгээлгэх шаардлага гарч, ажил олгогч нарыг чирэгдүүлж байна. Мөн шинээр ажил олгогч байгууллага бүртгэхэд тухайн ажил олгогч дээр 5-8 өөр ажил олгогчийн дугаар үүсэх тохиолдол гарсан.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу ажил олгогчийн төлөх үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 0.5, 1.5, 2.5 хувь, ажил олгогчийн төлөх ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг 0.5 хувь байхаар тус тус өөрчилснийг мөрдөн ажиллаж байна.

Улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс сард 792,000 төгрөг байхаар шинэчилэн тогтоосныг ажил олгогчид мөрдүүлэн ажилласан.

Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрөл кодын жагсаалтыг баримтлан ажиллаж байна.

Шинээр батлагдсан тогтоол, журам, тушаал, хуулийн хэрэгжилтийг ханган, мөрдөж ажиллах талаар ажил олгогч, даатгуулагчдад тус газрын пэйж хуудсаар тухай бүр хүргэн, ажил олгогчийн удирдлага, хүний нөөц, санхүүгийн ажилтнуудад системд ажиллах заавар зөвлөмжийг тухай бүр өгч, хууль журмын зүйл заалтыг тайлбарлан таниулж ажиллаж байна.

Нийгмийн даатгалын тухай хууль, журамд орсон нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх, шимтгэлийн тайланг үнэн зөв гаргах, даатгуулагчийн цалинг зөв тайлагнах, залруулга гаргахгүй ажиллах чиглэлээр ажил олгогчийн нягтлан бодогч нарт сар бүр зөвлөн туслаж, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг хүлээн авахдаа даатгуулагч бүрийн төрлийн кодыг зөв хэрэглэсэн эсэх үндэслэлийг нэгдсэн мэдээллийн сан /ndlav/-аас, зарим саруудад Sicos системээс нягтлан шалгаж хэвшсэнээр төрлийн код, бусад алдааг залруулан ажиллаж байна.

Ингэснээр нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг хуулийн хугацаанд төвлөрүүлж, тайлагнах, алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ажил олгогчдыг мэдээллээр хангах үр дүнтэй байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн “х” тайлан илгээх хүсэлтэй ажил олгогчийн тайланг системд хүлээн авч ажиллаж байна.

Цалин түүнтэй адилтгах орлогын дүнг буруу илгээсэн, тайлангийн үлдэгдэл зөрүүтэй татагдсан, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд даатгуулагчийн төрөл, ажил мэргэжлийн код буруу сонгосон, даатгуулагчийг орхиж тайлагнасан, цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг зөрүүтэй, буруу, илүү, дутуу тайлагнасан зэрэг шалтгаанаар 16 ажил олгогчийн ирүүлсэн албан бичиг, нотлох баримтыг хүлээн авч шийдвэрлэсэн

байна. Мөн байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтнууд солигдсон шинээр томилогдсон албан хаагчдын бүртгэлийг системд шинэчлэх хүсэлт нийт 18 байгууллагаас ирүүлснийг шийдвэрлэн ажиллав.

Сайн дурын даатгалын талаар

НДЕГ-ын даргын 2025 оны “Төлөвлөгөө батлах тухай” А/10 дугаар тушаалаар даатгалд шинээр хамруулах ажил олгогч, албан журмаар даатгуулагч, сайн дураар даатгуулагчийн тоон төлөвлөгөөг баталсан.

Төлөвлөгөө ёсоор 2025 онд 151, мөн оны эхний хагас жилд 76 даатгуулагчийг сайн дурын даатгалд шинээр хамруулахаас 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 160 даатгуулагчийг хамруулж, төлөвлөгөөг 211 хувиар биелүүлээд байна. Шинээр даатгалд хамруулсан сайн дурын даатгуулагчдыг төрлөөр нь ангилбал:

- ✓ малчин 22 (200%),
- ✓ 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх 13 (76,5%),
- ✓ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эх /эцэг/ 6 (54,5%),
- ✓ бусад 122 (286%) байна.

Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцэг сайн дурын даатгалд даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс сар бүр төлөх хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн хороодоос авсан судалгаагаар, эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 77 эх /эцэг/ байна.

Үүнээс албан журмын даатгалд 17, хуулиар тогтоосон болзол хангасан 29 иргэн сайн дурын даатгалд, даатгалгүй 31 эх /эцэг/ байна.


Малчин, туслах малчин сайн дурын даатгалд даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс сар бүр төлөх, улсын төсвөөс хариуцан төлөх хугацаа 5 жилээс ихгүй байх хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн хороодоос авсан судалгаагаар 1004 малчин (мал бүхий иргэн) байна.

Одоогоор сайн дурын даатгалд хамрагдах боломжтой малчдын судалгааг системээс малчин бүрээр шүүн ажиллаж байна. Оны эхний хагас жилийн байдлаар сайн дурын даатгалд 154 малчин хамрагдсан байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21 дэх хэсэгт заасны дагуу хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа эхчүүд нийгмийн даатгалын сангаас жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүссэн бол төлөх шимтгэлийн 50 хувийг өөрөө, үлдэх 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас төлөх, бусад эхийн төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс, 50 хувийг даатгуулагч эх өөрөө төлөхөөр зохицуулсан.

Тайлант хугацаанд дээрх зохицуулалтын хүрээнд нийгмийн даатгалын сангаас болон улсын төсвөөс шимтгэлийг хариуцан төлж буй 150 даатгуулагч эх байна.

Шинээр даатгуулагчдыг төрлөөр нь ангилан өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал:



Дээрх графикаас харвал сайн дурын даатгуулагчийн тоо өмнөх оноос буурсан нь 2025 оны 04 дүгээр сараас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг өсгөж, шинэчилэн тогтоосноос сард төлөх шимтгэлийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тэгвэл тайлант оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 999 иргэн сайн дурын хэлбэрээр нийгмийн даатгалд хамрагдсан байна. Нийт даатгуулагчдыг төрлөөр харуулбал:

Хүснэгт №02

	Даатгуулагчийн төрөл	/2024.01.01- 06.05/ даатгуулагчийн тоо	/2025.01.01- 05.31/ даатгуулагчийн тоо	Зөрүү
1	Шинээр	162	141	-21
2	Даатгуулагч эх	18	13	-5
3	Хөгжлийн бэрхшээлтэй асарч байгаа эх /эцэг/	20	6	-14
4	Сунгасан	962	839	-123
	Нийт дүн	1162	999	-163

Нийгмийн даатгалын санд 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 1006 даатгуулагчийн 384,7 сая төгрөг, 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 999 даатгуулагчийн 376,2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Сайн дурын даатгалын 2024 оны массивыг, 471 ширхэг зогсоогдсон хувийн хэргийн хамт жагсаалтаар архивт хүлээлгэн өгч, архивын нэгж бүрдүүлэв.

Тайлант оны эхэнд 588 даатгуулагчийн 18,7 сая төгрөгийн өглөгийн бүртгэлтэй байна. Өмнөх оны эхэнд 60 даатгуулагчийн 1,2 сая төгрөгийн өглөгийн бүртгэлийг оны эхний үлдэгдэлтэй харьцуулахад өссөн байгаа шалтгаан нь системийн шинэчлэлтэй холбоотой хугацаандаа нийгмийн даатгалын шимтгэлээ төлөөгүй 397 даатгуулагчийн 13,8 сая төгрөгийн алдангийн шимтгэл тайлант оны эхний үлдэгдэлд бүртгэлтэй байна. Одоогоор системийн шинэчлэлттэй холбоотойгоор өглөгийн бүртгэлийг нарийвчлан гаргах боломжгүй байна.

Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 03

дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 792,000 төгрөгөөр шинэчлэн баталж, 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Үүнтэй холбогдуулан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон шимтгэл төлж байсан сайн дурын даатгуулагчдад мэдээлэл хүргэж, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг 792,000 төгрөг болгон шимтгэлийн зөрүүг тооцон төвлөрүүлж байна. Нийт даатгуулчдын 86,8% буюу 867 иргэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр орлого тодорхойлж сайн дураар даатгуулж байна.

Нийгмийн даатгалын шинэчлэн батлагдсан багц хуулийг иргэд даатгуулагчдад сурталчлан таниулах мөн шинэ Sicos систем нэвтрүүлсэнтэй холбоотойгоор программд даатгуулагчдын мэдээллийг үнэн зөв бүртгэх, сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, гэрээний төрөл шинэчлэн бүртгэх зэрэг цаг үеийн ажлуудыг гүйцэтгэж ажиллав.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

Ажил олгогч, даатгуулагчдад хийсэн хяналт шалгалтын талаар

Тайлант хугацаанд хяналт шалгалтаар 7 ажил олгогч, 9 даатгуулагчид холбогдох ажилласан хугацааны хөдөлмөрийн хөлс, жирэмсэн амарсаны амралттай хугацаа, нэг сараас дээш хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдсан хугацаа, хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацааны шимтгэл, ээлжийн амралтын олговрыг харгалзах сард нь залруулах тухай хүсэлтийг судлан нотлох баримтад үндэслэн шалгаж 2821,4 мянган төгрөгийн акт тогтоогдож 4 ажил олгогчийн 454,7 мянган төгрөгийг актын төлбөрийг барагдуулж, 2366,7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2025 оны эхний үлдэгдэлтэй 4 ажил олгогчийн 194,7 мянган төгрөгийн улсын байцаагчийн актыг бүрэн барагдуулсан байна.

Өмнөх онд Нийгмийн даатгалын ерөнхий газрын, хяналт шалгалтын газрын нийгмийн хамгааллын улсын байцаагчийн Нүүрээнтэй эсгий ХХК-д тогтоосон 2081,8 мянган төгрөгийн акт 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар барагдуулаагүй байна. Тус компанийн захирал болон нягтлан бодогч нартай удаа дараа холбогдоход улсын байцаагчийн актыг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн тайлбар өгсөн байна.

2024 онд сайн дурын даатгалын шимтгэлийг гэрээний хугацаанд, хугацаа хоцроож төлсөн 574 даатгуулагч (давхардсан тоогоор)-д 13864.9 мянган төгрөгийн алданги тогтоож бүрэн барагдуулсан боловч Сикос программд сайн дурын даатгалын алданги ногдуулалт хийх боломжгүй, программд хөгжүүлэлт хийгдээгүй байсан тул алдангийн өглөгтэй гарсан байна. Тус актыг хяналт шалгалтын тайлангаас хасаж, 2025 оны тайланд тусгахаар шийдсэн.

Цалин шалгуулахаар хүсэлт гаргасан 4, мал тооллогын А дансыг шалгуулах 3, ээлжийн амралтын цалин, цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогыг харгалзах сард нь залруулах, тайланд тусгаагүй цалин хөлс, түүнтэй адилтгах орлого нөхөн

тайлагнуулах 16 өргөдлийг архивын баримт, тушаал, бусад нотлох баримтад үндэслэн тулган шалгаж, залруулах дүгнэлт гарган, санхүүгийн ажилтанд шилжүүлж, хариуг хуулийн хугацаанд хүргүүлсэн байна.

Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйл “Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах”, 15.2 дугаар зүйл “Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах” заалтын дагуу дараахь зөрчлүүдийг шалган шийдвэрлэсэн байна.

Зөрчлийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж нийт 2 ажил олгогч байгууллагатай холбоотой нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн, нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалтын ЗНД-7, ЗНД-8 тайланг хуульд заасан хугацаанд тайлагнаагүй нөхөн тайлагнах, ажил олгогч, улсын бүртгэлийн байгууллагаас гэрчилгээ авснаас хойш ажлын 14 өдрийн дотор харьяалагдах “нийгмийн даатгалын байгууллагад нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн, нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлэх зэрэг хэрэг материалд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 2 ажил олгогч байгууллагатай холбоотой хэрэг материалыг хялбаршуулсан журмаар шалган хянан шийдвэрлэж, 750000 төгрөгийн торгууль ногдуулсан байна.

д/д	Байгууллагын нэр	Регистер	Даатгуулагчийн тоо	Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн эсэх	Зөрчлийн торгуулийн мөнгөн дүн төгрөгөөр
1	Боорчи ухаант хонгор ХХК Захирал Э.Өсөхбаяр	4558618	1	тийм	250 000
2	Тэнүүн тусгал ХХК Захирал А.Билгүүн	4560388	1	тийм	500 000
Нийт дүн					750 000

Дотоод хяналт шалгалтын талаар

Дотоодын хяналт шалгалтаар тахир дутуугийн тэтгэврээс өндөр насны тэтгэвэрт шилжсэн, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь өөрчлөгдсөн, гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоо өөрчлөгдсөн, нөхөн даатгалын жил болон шимтгэл төлж ажилласан жил, цалин өөрчилсөн хуучин тэтгэвэртэй 276, шинээр тогтоолгосон 128,

шилжиж ирсэн 5, тусгай зохицуулалт 8, нийт 417 тэтгэвэр авагчийн хувийн хэрэг материалын үндэслэл, тооцооллыг шалгалаа. Хүснэгтээр харуулбал:

№	Тэтгэврийн төлөв	Тэтгэврийн төрөл	Тоо хэмжээ
1	Нийт 417 тэтгэвэр - Үүнээс:	Өндөр насны тэтгэвэр	204
		Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	173
		Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	40
		Шинэ	128
2	Нийт 417 тэтгэвэр - Үүнээс:	Хуучин	276
		Шилжиж ирсэн	5
		Тусгай зохицуулалт	8
3	Нийт 417 тэтгэвэр - Үүнээс:	Эр	198
		Эм	219

Шалгалтаар зарим саруудын цалин зөрүүтэй бичих, цалингийн орон хаях, архивын лавлагаа, төрсний бүртгэлийн лавлагаа, мэдээллийн бааз, нийгмийн даатгалын дэвтрүүд дээрх цалингууд зөрөх, нийгмийн даатгалын дэвтэрт цалинг баталгаажуулаагүй мөн 5 жилийн цалингийн тодорхойлолтыг хяналтаар баталгаажуулаагүй, хөдөлмөрийн дэвтэр болон иргэний үнэмлэхний овог зөрүүтэй, шимтгэл төлөлтийн архивын лавлагаа дутуу, байгууллагын нэр өөрчилсөн лавлагаа дутуу, ээлжийн амралтын хязгаарлагдаагүй хөдөлмөрийн хөлсийг хуваан тэтгэврийн программд шивээгүй, Засгийн газрын тогтоолоор нэмэгдсэн тэтгэврийн нэмэгдлийг хувийн хэрэгт тэмдэглээгүй, ажилласан жил зөрүүтэй оруулах зэрэг зөрчлүүд гарсныг тухай бүр засуулж, гарч байгаа алдааг давтахгүй байх, алдаа гарахаас сэргийлэх талаар тэтгэврийн байцаагчид зөвлөгөө өгч ажиллав.

Өмнөх онд тогтоогдсон 10 тэтгэвэр авагчтай холбоотой 98761,4 мянган төгрөгийн улсын байцаагчийн актын төлбөрөөс тайлант хугацаанд барагдуулаагүй байна.

2025 оны эхний үлдэгдэлтэй хуурамч баримтаар тэтгэвэр тогтоолгосон 20 тэтгэвэр авагчийн 409822,98 мянган төгрөгийн актын төлбөрөөс барагдуулаагүй, 409822,9 мянган төгрөг үлдэгдэлтэй байна.

Тайлант хугацаанд 4 тэтгэвэр авагчид илүү болон дутуу олгосон 13900,4 мянган төгрөгийн акт тогтоогдож, 9492,8 мянган төгрөгийг барагдуулсан байна.

Нэг тэтгэвэр авагчид илүү олгосон 4407,6 мянган төгрөгийг 2025 оны 07 дугаар сараас төлж эхлэхээр хуваарь гаргаж, гэрээ байгуулав.

Ажилгүйдлийн тэтгэмж авахаар өргөдөл хүсэлт гаргасан 149 даатгуулагчдын хувийн хэрэг материалын тэтгэмжийн бодолт, баримт материалын бүрдэлт, хуулийн хугацаа зэргийг шалгасан.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний, амаржсаны тэтгэмж: 156
байгууллагын 1153 даатгуулагч, сайн дурын 108 даатгуулагчдын эмнэлгийн хуудсыг зохих журмын дагуу хянаж, шалгав. Үүнд:

Хүснэгт №10

№	Байгууллага	Тэтгэмжийн төрөл	Тоо хэмжээ
1	Нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагч – 108	ЖАТ	47
		ХЧТА	61
		Эр	23
		Эм	85
2	156 ажил олгогч байгууллагын тэтгэмж авсан даатгуулагч 1153	ЖАТ	147
		ХЧТА	1002
		ҮОМШӨ ХЧТА	4
	Нийт дүн		1261

Нэг даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн актын төлбөр 1089,6 мянган төгрөг барагдаагүй үлдэгдэлтэй байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 13-07/06 дугаартай "Ажилгүйдлийн даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай" удирдамж

Уг удирдамжийн дагуу тус нийгмийн даатгалын газарт Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч Б.Хишигжаргал ахлан, улсын байцаагч Г.Бямбажаргал, О.Пүрэвжав нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2025 оны 05 дугаар сард ирж ажиллалаа.

Шалгалтаар ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалттай холбогдох санхүүгийн баримт материал, нягтлан бодох бүртгэл, цалин хөлс, санхүүгийн анхан шатны баримт, аж ахуйн нэгж, байгууллагын тушаал шийдвэр, иргэн болон ажилтантай байгуулсан холбогдох гэрээнд тулгуурлан шалгасан ба шалгалтын дүн эцэслэж гараагүй байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн “Аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамж”-ийн биелэлт

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/336 дугаар албан бичгээр ирүүлсэн удирдамжийн дагуу, тус газрын Захиргаа хяналтын хэлтсийн дарга, Нийгмийн даатгалын улсын байцаагч Г.Батболд, хяналт шалгалтын байцаагч, Нийгмийн даатгалын улсын байцаагч Х.Тогтвор нар хувийн хэвшлийн ерөнхий боловсролын Сод сургуулийн 2020-2024 оны санхүүгийн болон холбогдох бусад баримтад үндэслэн нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж байна.

Шилэн дансны мэдээлэл байршуулалтад хийсэн шалгалтын талаар

Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн “Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай” 03 дугаар Албан даалгавраар өгөгдсөн үүрэг даалгавартай холбогдуулан тус газрын шилэн дансны 2025 оны 01 дүгээр улирлын мэдээллийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дотоод аудит мониторингийн газраас шалгасан байна.

Мэдээллийн ил тод байдал, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагааны төсөв, зардалтай холбоотой 28 төрлийн 171 мэдээ, мэдээллийг <https://info.shilendans.gov.mn/> цахим хуудаст байршуулахаас 68 мэдээ байршуулсан, 2 мэдээ нь засвар орсон тул хугацаа хоцорсон төлөвт шилжсэн, хугацаа болоогүй 103 мэдээ хүлээгдэж байна. Мөн олон нийтэд хүртээмжтэй хүргэх зорилгоор “Ил тод, нээлттэй байдал, шилэн дансны мэдээллийн самбар”-т тухай бүр байршуулсан байна.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРДАЛ

Нийгмийн даатгалын сангийн зарлага, санхүүжилт, үйлчилгээний талаар

2025 оны 05 дугаар сарын 31-ний байдлаар нийгмийн даатгалын сангуудаас зарцуулсан зарлагыг сан, зардлын төрөл тус бүрээр нь харуулбал:

1. Тэтгэврийн даатгалын сан:

д/д	Тэтгэврийн төрөл	Дүн мян.төг-өөр
1.	Өндөр нас	20,798,740.23
2.	Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	1,554,606.99
3.	Тэжээгчээ алдсан	730,362.47
4.	Цэргийн өндөр нас	2,202,794.55
Дүн		25,286,504.24

Тэтгэмжийн даатгалын сангаас:			/мян.төг-өөр/
д/д	Тэтгэмжийн төрөл	Хүний тоо	Дүн
1.	ХЧТА	621	310,155.53
2.	ЖАТ	184	716,293.23
3.	НБДГБГ олгох тэтгэмж	56	112,000.00

Дүн

861

1,138,448.76

3.ҮОМШӨ-ий даатгалын сангаас:

/мян.төг-өөр/

д/д	Төрөл	Хүний тоо	Дүн
1.	Тахир дутуугийн тэтгэвэр	129	836,051.99
2.	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	16	89,619.25
3.	Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний зардал	91	73,080.00
4.	ҮОМШӨ Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж	1	2,000.0
5.	ХЧТА	2	8229.37
Дүн		239	1,008,980.61

4.Ажилгүйдлийн даатгалын сангаас:

д/д	Төрөл	Хүний тоо	Дүн
1.	Ажилгүйдлийн тэтгэмж	133	602,913.31
2.	Сургалтын зардал	0	0
Дүн		133	602,913.31

Нийгмийн даатгалын сангийн зарлага

/мян.төг-өөр/

Д/д	Сан	Төлөвлөгөө	гүйцэтгэл	Хэмнэлт	Хэтрэлт
1.	Тэтгэвэр	25,313,906.50	25,289,037.22	24,869.28	
2.	Тэтгэмж	1,194,325.20	1,138,620.17	55,705.02	
3.	ҮОМШӨ	1,716,119.90	1,007,192.49	708,927.41	
4.	Ажилгүйдэл	597,771.30	602,947.95		5,176.65
Дүн		28,822,122.90	28,037,797.84	789,501.71	5,176.65

2025 онд авсан санхүүжилт, төвлөрүүлэлт

/мян.төг-өөр/

д/д	Сангийн төрөл	Авсан санхүүжилт	Төвлөрүүлсэн мөнгө
1	Төвлөрсөн харилцах		16,818,514.84
2	Тэтгэвэр	16,911,354.10	
3	Тэтгэмж	1,192,931.60	
4	ҮОМШӨ	882,000.00	
5	Ажилгүйдэл	597,771.30	
Дүн		19,584,057.00	16,818,514.84

Улсын төсвийн санхүүжилт

/мян.төг-өөр/

Д/д	Дүн
1	Тэтгэвэр 8,802,355.10
2	Тэтгэмж 1,393.60
3	ҮОМШӨ 28,223.00
Дүн	8,831,971.70

2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тэтгэврийн даатгалын сангийн бусад авлага оны эхний 17,610.61 мянган төгрөг, 2025 оны тайлант хугацаанд нэмэгдсэн

1,808.53 мянган төгрөг, нийт 19,419.14 мянган төгрөг, тэтгэмжийн даатгалын сангийн бусад авлага оны эхний 1,405.49 мянган төгрөг, ҮОМШӨД Сангийн бусад авлага оны эхний 100.0 мянган төгрөг, 2025 оны тайлант хугацаанд нэмэгдсэн 1,203.09 мянган төгрөг нийт 1,303.09 мянган төгрөгөөс тайлант хугацаанд 1,085.46 мянган төгрөг барагдуулж 217.63 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, ажилгүйдлийн даатгалын сангийн оны эхний авлага 6,926.21 мянган төгрөг, тайлант хугацаанд 2,101.31 мянган төгрөг нэмэгдэж нийт 9,027.52 мянган төгрөгөөс тайлант хугацаанд 3,247.22 мянган төгрөгийг барагдуулж 5,780.29 мянган төгрөгийн тус тус үлдэгдэлтэй байна. Оны эхний тэтгэврийн акт нийт 508,669.64 төгрөг, тайлант хугацааны 8,672.40 мянган төгрөгийн актын төлбөр барагдсан байна.

ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТАЛААР

Тайлант хугацаанд ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан тэтгэвэр тогтоох, олгох, мэдээллийн сан бүрдүүлэх, баталгаажуулах, өөрчлөх, түүнд тавих хяналт, тайлан мэдээ, судалгаа гаргах, хувийн хэргийн хадгалалт хамгаалалт, бүрдэл эмх цэгцийг сайжруулах, удирдлагыг мэдээллээр хангах үндсэн ажил үүргийг гүйцэтгэлээ. Тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлыг дараах байдлаар бүлэглэн тайлагнаж байна. Үүнд:

Тэтгэвэр тогтоох, өөрчлөх, олгох үйл явц

Иргэн, даатгуулагчид тэтгэвэр тогтоох, олгох, тэтгэврийг өөрчлөхөд Нийгмийн даатгалын багц хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад хууль, тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэв.

2025 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар тэтгэврийн даатгалын сангаас 5238 хүнд 25 286 540.00 мянган төгрөгийн, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 136 хүнд 925 670.00 мянган төгрөгийн, нийт 5374 хүнд 26 212 210.00 мянган төгрөгийг олгоод байна.

Тэтгэврийн олголтыг өмнөх оны мөн үетэй төрлөөр нь харьцуулбал:

д/д	Тэтгэвэр авагчдын төрөл	2024.05.31-ний байдлаар	2025.05.31-ний байдлаар	Зөрүү	Хувь
1	Өндөр насны	4425	4552	127	2.9
2	ХЧА	638	570	-68	-10.7
3	Тэжээгчээ алдсаны	247	252	5	2.0
4	Нийт	5310	5374	64	1.2

Тайлант хугацаанд ХХҮХ-т тэтгэврийн эрх үүсээгүй тодорхойлолт 13, эрх үүссэн тодорхойлолт 1, НДГ-ын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлд өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн тодорхойлолт 4-ийг гарган өгч хамтран ажиллав.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заагдсан тэтгэвэр тогтоолгох, мөн хуулийн 29.3, 9.2-т заасны дагуу тэтгэврийн хэмжээг өөрчлүүлэх, шилжиж ирсэн болон шилжиж явсан нийт 262 даатгуулагч иргэний өргөдлийг хүлээн авч шийдвэрлэлээ.

Шинээр тогтоогдсон тэтгэврийг өмнөх оны мөн үетэй төрлөөр нь харьцуулбал:

График №01



Тэтгэврийн хөдөлгөөнийг хүснэгтээр харуулбал:

д/д	Тэтгэврийн хөдөлгөөн	Өндөр нас	Хөдөлмөрийн чадвар алдсан	Тэжээгчээ алдсан	Дүн
1	Шинээр тогтоосон	88	26	5	119
2	Шилжиж ирсэн	3	1	0	4
3	Шилжиж явсан	11	5	1	17
4	Тусгай зохицуулалт	9	0	0	9


ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВРИЙН ТУСГАЙ ЗОХИЦУУЛАЛТ

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн (шинэчилсэн найруулга) тухай хуулийн 9 дүгээр зүйлд нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд түүний авч байсан сарын тэтгэврийн 20 хувиар тооцсон дүнгээр өндөр насны тэтгэвэр авагч нөхөр (эхнэр)-ийн сарын тэтгэврийг нь нэмэгдүүлэхээр зохицуулсан.

Тайлант хугацаанд тэтгэвэр авагч 41 хүний гэр бүлийн гишүүдэд нас барсаны дараа сарын тэтгэвэр олгосноос, 9 даатгуулагчийн өндөр насны тэтгэврийг тус бүр 20 хувиар нэмэгдүүлэн нас барсны дараагийн 2 дахь сараас эхлэн сар бүр олгож байна.

Тусгай зохицуулалтын хүсэлтийг сараар харуулбал:

График №02



Банк өөрчлөх хүсэлт

Тайлант хугацаанд 50 даатгуулагчийн хүсэлтийг хүлээн авч, тэтгэврийг сонгосон банкаар олгов. Арилжааны банкууд илүү урт хугацаатай, таатай нөхцөлтэй дижитал тэтгэврийн зээлийг олгох тохиолдолд банк өөрчлөх хүсэлт ихэсдэг.

Тэтгэвэр олгох файл бэлтгэх, арилжааны банкинд илгээх

Sicos системээр тэтгэвэр авагчийн сонгосон арилжааны банкинд тэтгэвэр тэтгэмжийн хэлтсийн дарга, хяналт шалгалтын байцаагч, тэтгэврийн тогтоолт, олголт хариуцсан байцаагч, мэдээллийн технологи сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтан нар хамтран сар бүрийн сүүлийн ажлын өдөрт, НДЕГ-с ирсэн чиглэлийн дагуу 7 хоног бүр нэг удаа, нийт 21 удаагийн давтамжтайгаар тэтгэвэр олголтын файлыг бэлтгэн Хаан, Төрийн, Голомт, Хас банкинд илгээснээр тэтгэврийг хугацаанд нь тавьж олголоо.

Тэтгэвэр тогтоолт, олголтод хийсэн хяналт

ННДГ-ын 2021.02.08-ны өдрийн 03/26 тоот албан бичгийн дагуу Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр 2007-2021 онд тогтоогдсон 149 тэтгэврийн хувийн хэрэг шалгаж, 2022 оны 03 дугаар сараас 125 тэтгэврийн олголтыг түдгэлзүүлэн зогсоосон.

Эдгээрээс 121 хүний тэтгэврийн баримтыг хуурамчаар бүрдүүлсэн эсэхийг шалгуулахаар Цагдаагийн байгууллагад шилжүүлсэнээс 118 тэтгэврийг хэрэг бүртгэлийн хэрэг нээж, шалгаад, 2024 оны 08 дугаар сард Багануур дүүргийн Прокурорын газарт шилжүүлэн, үргэлжлүүлэн шалгагдаж байна.

Түдгэлзүүлсэн 118 тэтгэврээс:

- НДЕГ-аас ирүүлсэн чиглэл, зөвлөмжөөр 2023 оны 01, 07 дугаар саруудад 103 тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчилж, шинэчлэн тогтоосон.
- Тэтгэвэр тогтоолгох нас, ажилласан жилийн болзол хангахгүй 5 хүнд тогтоох эрх үүсэхгүй байна.
- Тэтгэвэр авагч 12 хүн шалгалтын явцад (2 хүн тэтгэвэр тогтоолгон авч байгаад) нас барсан байна.

Зөвлөгөө өгөх өргөдөл хүлээж авах үйл явц

Тайлант хугацаанд Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Засгийн газрын болон Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэл, Дүүргийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтод тусгагдсан Нийгмийн даатгалын тухай хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон төрийн захиргааны удирдах дээд шатны байгууллагуудаас гаргасан тушаал, захирамж, тогтоол, шийдвэр, албан даалгаврыг хэрэгжүүлэн биелүүлж, ажил олгогч даатгуулагчдад хөнгөн шуурхай үйлчилж, зөвлөгөө зөвлөмжийг тухай бүр утсаар, цахимаар болон биечлэн хүргэж, гаргасан өргөдөл хүсэлтийг хүлээн авч, сангаас олгох тэтгэврийг цаг хугацаанд нь тогтоон, олгож ажиллалаа.

➤ Иргэд даатгуулагчдад хууль эрх зүйн зөвлөгөө, зөвлөмж өгөх үндсэн ажлын хүрээнд

2025 оны эхний хагас жилийн байдлаар 135 иргэнд Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль болон эдгээр хуулийг хэрэгжүүлэх тухай журам, дүрэм, заавар, зөвлөмж, бусад холбогдох хууль тогтоомжуудыг сурталчлах, хэрэгжилтийг хангуулах талаар зөвлөн туслав.

Тайлант хугацаанд тэтгэвэр тогтоолгох, баримт бичгийн зөрчил арилгуулах, шимтгэл төлж ажилласан жил хэрхэн тооцох, тэтгэвэр тогтоолгох насны болзол, малчны тэтгэвэр, хөдөлмөрийн хөнгөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох болзол, тэтгэврийн өөрчлөлт, олголт зэрэг асуудлаар даатгуулагч, тэтгэвэр авагч иргэдэд цахимаар, утсаар болон биечлэн зөвлөгөө өгч, тэтгэвэр тогтоолгоход шаардагдах баримт бичгийн бүрдэл, зөрчлийг арилгах, урьдчилсан тооцоолол хийлгэхээр ирсэн 693 даатгуулагчид мэдээлэл зөвлөгөө өгч зөвлөмжийн хуудас бичиж, баталгаажуулан үйлчиллээ.

Тэтгэвэр авагчид чиглэсэн ажил үйлчилгээний талаар

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан Нийгмийн даатгалын ерөнхий хууль (шинэчилсэн найруулга)-д орсон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль (шинэчилсэн найруулга), Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай (шинэчилсэн найруулга) хуультай холбоотой шинэлэг зохицуулалтуудыг дурдвал:

1. 2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нийт тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулж 6 хувиар нэмэгдүүлэх Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрээр нийт 5341 тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлж, нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн болон цэргийн тэтгэврийн доод хэмжээ сард 689,000 төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 572,400 төгрөг, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай болон Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн тухай хуулийн дагуу гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй 3 ба түүнээс дээш гишүүнд олгох тэжээгчээ алдсаны шинээр тогтоолгосон бүрэн тэтгэврийн доод хэмжээ 792000 төгрөг, хуучин тэтгэвэр нь 805600 төгрөг болсон.

“Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон акт”, “Тэтгэвэр тогтоолтын хуудас”-ыг E-Mongolia системд холбосноор зээл авах, виз мэдүүлэх зэрэгт баримт бичиг бүрдүүлэхэд хялбар болсныг иргэдэд сурталчилж байна. Үндэсний төв архив, аймгийн архивын тасгаас авах лавлагааны хүсэлтийг цахимаар гаргах, Батлан хамгаалах яамны төв архиваас цэргийн лавлагааг E-Mongolia-с авахыг зөвлөж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газраас цахимаар авахуулж байна.

Тэтгэврийн хувийн хэргийн хадгалалт хамгаалалт

Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх заалт, тус газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/26 дугаар тушаалыг үндэслэн ажлын хэсэг 2025 оны 01 дугаар сарын 02-

ны өдрөөс 2025 оны 01 дугаар сарын 06-ны өдрийн хооронд өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэврийн хувийн хэргийг нэг бүрчлэн үзэж Sicos системээс гаргаж авсан массивтай овог нэрээр нь тулган шалгаж, тоолсон.

Тус газраас 2023 онд 5189 иргэн тэтгэвэр авч байсан бол тайлант хугацаанд 5347 иргэн тэтгэвэр авч нийт тэтгэвэр авагчийн тоо 158 хүнээр буюу 3.04 хувиар өссөн байна.

Тус газраас тэтгэвэр авч байгаа 5347 иргэний тэтгэврийн хувийн хэрэг **илүүдэл, дутагдалгүй** бүрэн бүтэн ашиглагдаж байна.

➤ Архивын нэгж бүрдүүлэлт

2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу зогсоогдсон өндөр насны тэтгэврийн хувийн хэрэг 91, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн хувийн хэрэг 123, тэжээгчээ алдсаны тэтгэврийн хувийн хэрэг 11 нийт 225 тэтгэврийн хувийн хэргийг эмхэлж цэгцлэн 2025 оны 1 дүгээр улиралд багтаан хадгаламжийн нэгжийг бүрдүүлэн, архивт шилжүүлсэн.

Бусад

Нийгмийн даатгалын шинэчлэн батлагдсан багц хуулийг иргэд даатгуулагчдад сурталчлан таниулах, Даатгуулагчийг дэмжих, Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах, Нийгмийн даатгалын цогц системээр 2024 оны санхүүгийн тайланг гаргасан онцлог жил байна.

2025 оны итгэлцүүр өөрчлөн батлагдсантай холбоотой Sicos программ дээр өөрчлөлт хийх ажлаас шалтгаалан 2025 оны 01 дүгээр сарын шинэ тогтоолт, олгох ажлууд удааширсан.

Тайлант хугацаанд Sicos программд даатгуулагчдын мэдээллийг үнэн зөв бүртгэх, шинэ тэтгэврийг хуулиар тогтоосон цаг хугацаанд тогтоож олгох, ажилласан жилийн нэмэгдэл зэрэг цаг үеийн ажлуудыг хийн ажиллаж байна.

ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН ТАЛААР

Тайлант хугацаанд даатгуулагчдад чирэгдэл багатай, асуудлыг тухай бүр арга хэмжээ авч тэтгэмжийг цаг хугацаанд хэвийн олгоход анхаарч ажилласан.

Тайлант хугацаанд тэтгэмжийн даатгалын сангаас 1.822.671,4 мянган төгрөгийн тэтгэмж тогтоож олгосон.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн хүсэлт шийдвэрлэлт


Ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан 1134 (давхардсан тоогоор) даатгуулагчийн эмнэлгийн хуудсыг эрүүл мэндийн байгууллагаас 100 хувь цахимаар хүлээн авч, 14 хоногийн дотор шийдвэрлэн 310.155,5 мян төгрөгийн тэтгэмж олгосон.

Тэтгэмж авах эрх үүсээгүй, мэдээлэл дутуу, програмын хэвийн бус ажиллагаа, бусад шалтгаанаар 136 хүсэлт цуцлагдсан.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн хүсэлт шийдвэрлэлт:


ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАН ТЭТГЭМЖ

■ Шийдвэрлэсэн 1134 ■ Цуцалсан 136 ■ Боловсруулж байгаа 0



Жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийн хүсэлт шийдвэрлэлт:

Жирэмсэн болон амаржсаны тэтгэмж



Цахим эмнэлгийн хуудсыг үндэслэн 137 даатгуулагчийн жирэмсэн болон амаржсаны тэтгэмжид 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 716.293,2 мянган төгрөгийг олгоод байна.

Тэтгэмж авах эрх үүсээгүй, харъяаллын бус, бусад шалтгаанаар 26 хүсэлт цуцлагдсан.

Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 8 дугаар тогтоолын дагуу нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн 56 баримт материалыг шалган хүлээн авч, цахим системд мэдээллийг бүртгэж 112.000,0 мянган төгрөг арилжааны банкаар дамжуулан 24 цагийн дотор гэр бүлийн гишүүдэд олгосон.


Эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолтоор амьгүй донор болж тэтгэмж авсан тохиолдол гараагүй.

Нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаагүй, төлж байсан боловч тэтгэмж авах эрх үүсэх хугацаа хүрээгүй шалтгаанаар 4 хүнд тодорхойлолт гаргаж өгсөн.

Ажилгүйдлийн тэтгэмж

Тайлант хугацаанд буюу 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 145 хүсэлт ирснээс, даатгуулагчийн цахимаар болон цаасаар өгсөн өргөдөл, ажлаас чөлөөлөгдсөн тушаал, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн тухай тодорхойлолтыг үндэслэн 116 хүсэлтийг шийдвэрлэж, ажлын 76 хоног дуустал хугацаанд сар бүр даатгуулагчийн арилжааны банкны дансаар дамжуулан 571.198,7 мянган төгрөг олгохоор тооцон, тэтгэмжийг хуваарийн дагуу олгож байна. Дээрхээс 10 хүсэлт хяналтын шатанд боловсруулагдаж байна.

Харин харьяаллын бус, мэдээлэл алдаатай, эрх үүсээгүй зэрэг шалтгаанаар 19 даатгуулагчийн хүсэлт цуцлагдлаа.



Тайлант хугацааны ажилгүйдлийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн зардлыг сүүлийн 2 жилийн мөн үетэй харьцуулахад өссөн байгаа нь графикаас харагдаж байна. Энэхүү өсөлтөд нөлөөлж байгаа хүчин зүйлсэд ажлаас чөлөөлөгдсөн хүний тоо нэмэгдсэн. Мөн нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулиар ажилгүйдлийн даатгалыг тооцох хувь хэмжээ өмнөх хуулиар 45, 50% байсан бол хуулийн шинэчлэсэн найруулгаар 50, 55, 60, 70% болж өссөн болон хүсэлт хүлээн авах 14 хоногийн хугацаа дуусвал хүлээн авдаггүй байсан бол одоо хүсэлт хүлээн авах 28 хоногийн хугацаа дууссан ч хүлээн авч тэтгэмж олгох 76 хоногоос хасч олгодог болсон нь нөлөөлжээ.

Рашаан сувиллын зардал

Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох хэмжээг НДҮЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолоор ор хоногийн мөнгө 70,0 мянган төгрөг болж нэмэгдсэн.

Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ҮОМШӨ-ний даатгалын сангаас “Багануур сувилал” ХХК-иар үйлчлүүлсэн 87 хүний 73.080,0 мянган төгрөгийн санхүүжилтийг жагсаалтаар олгосон.

ҮОМШӨ сувилалд ирж очих унааны зардал авах 1 хүний хүсэлтээр 70,0 мянган төгрөг олголоо.

ҮОМШӨ-ний шалтгаанаар хөдөлмөрийн чадвар түр алдсан 2 даатгуулагчид 8.229,4 мянган төгрөгийн тэтгэмжийг тооцож, олгов.

Тус газрын 2025 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг хэлтсийн дарга нараас санал авч боловсруулан, нийт 124 хөтлөх хэргийн жагсаалтыг батлуулсан. Үүнд:

Цаасан суурьтай баримт:

- ✓ Байнга хадгалах хэргийн тоо 39
- ✓ 70 жил хадгалах хэргийн тоо 13
- ✓ Түр хадгалах хэргийн тоо 72

Цахимжуулсан баримт:

- ✓ Байнга хадгалах хэргийн тоо 39
- ✓ 70 жил хадгалах хэргийн тоо 12
- ✓ Түр хадгалах хэргийн тоо 59

Тус газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/13 дугаар тушаалаар байгуулагдсан тооллого явуулах комисс нь 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийг хүртэлх хугацаанд 13367 хадгаламжийн нэгжийг тоолов.

Архивын сан хөмрөгт байгаа хадгаламжийн нэгжийг данс бүртгэлээр нэг бүрчлэн тулгахад хадгалах хугацаа дууссан 308, дутагдсан 17 хадгаламжийн нэгж, 72 хувийн хэрэг, 2 иргэний нөхөн даатгалын материал, сэлбэн засварлах 23, данс бүртгэл солих 12, хадгалах хугацаа дууссан 308, баримтын бүрдэл дутуу 455, данс бүртгэлд тэмдэглэсэн жагсаалтын зүйлийн дугаар, хадгалах хугацаа хадгаламжийн нэгжийнхээс зөрүүтэй 33, хөгцөрч гэмтсэн 1, он цагийн хязгаар зөрчиж, 2-оос дээш оны материалыг хамтад нь үдсэн 17, данс бүртгэлд бүртгээгүй 1 хадгаламжийн нэгж, сайн дурын даатгалын 93 хувийн хэрэг тус тус байна.

д/д	Данс бүртгэл	Баримтын тооллого	Тоо хэмжээ
1	Байнга	Дутагдсан	8
2		Прокурорт шилжүүлсэн	10
3		Бэлэн тоологдсон	332
Дүн			350
1	70 жил хадгалах	Бэлэн тоологдсон	1025
2		Дутагдсан	0
Дүн			1025
1	Шимтгэл 70 жил хадгалах	Дутагдсан	1
2		Бэлэн тоологдсон	711
Дүн			712
1	Түр хадгалах	Дутагдсан	8
2		Бэлэн тоологдсон	1230
3		Илүүдсэн	1
Дүн			1239
1	Өндөр насны тэтгэвэр авагчдын зогсоогдсон хувийн хэрэг	Гэр бүлийн гишүүн авсан	3
2		Тэтгэврийн байцаагчид шилжүүлсэн	2
3		Шалтгаан тодорхойгүй	16
4		Бэлэн тоологдсон	2411

Дүн			2432
1	Тахир дутуугийн тэтгэвэр авагчдын зогсоогдсон хувийн хэрэг	Өөрөө болон гэр бүлийн гишүүн авсан	12
2		Тахир дутуугийн тэтгэвэрт дахин орсон	2
3		Тэтгэврийн байцаагчид шилжүүлсэн	2
4		Шалтгаан тодорхойгүй	24
5		Бэлэн тоологдсон	1606
Дүн			1646
1	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын зогсоогдсон хувийн хэрэг	Иргэн өөрөө авсан	1
2		Шалтгаан тодорхойгүй	10
3		Бэлэн тоологдсон	922
Дүн			933
1	Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуульд хамрагдсан иргэний материал	Дутагдсан	2
2		Бэлэн тоологдсон	5028
Дүн			5030
1	Тусгай төрлийн баримт (бүртгэл, жагсаалт байхгүй)	Цахимжуулсан баримт /CD/	26
2		Зургийн цомог	1
Дүн			27

Тайлангийн хугацаанд байгууллагын үйл ажиллагааны цаасан болон цахимжуулсан 2024 оны баримтыг 2025 оны 01 дүгээр улиралд хүлээн авах хуваарийг батлуулсан хэдий ч албан хаагчдын ажлын ачааллаас шалтгаалан хойшлогдсон.

Эхний хагас жилийн байдлаар :

- ✓ Өндөр насны тэтгэвэр авагчдын зогсоогдсон хувийн хэрэг 91
- ✓ Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчдын зогсоогдсон хувийн хэрэг 123
- ✓ Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчийн зогсоогдсон 11 хувийн хэргийг тус тус хүлээн авсан.

Байгууллагын архивын хөмрөг хадгалах өрөөний хэвийн чийг, дулаан, аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлан, чийг, дулааныг хэмжигч термометрийн заалтыг Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журамд заасны дагуу 7 хоногт 3-аас доошгүй удаа хэмжин, цэвэрлэгээг 7 хоногт 1 удаа хийж, тэмдэглэл хөтөлж байна.

Архивын өрөөний чийг журамд зааснаар цаасан суурьтай баримт (+14)-өөс (+16) градус, харьцангуй чийгшил 50-55% -тай байхаас халаалттай үед 40%-аас дээш гарахгүй байгаагаас баримтын хадгалалтын горим алдагдаж, чанар байдлаа алдах эрсдэлтэй тул агаар чийгшүүлэгч суурилуулах шаардлагатай байна.

2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газрын Архивын хэлтсээс архивын улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангуулах, зөвлөн туслах, урьдчилсан үзлэг явуулахтай холбоотойгоор тавиур, шүүгээ тус бүрийг дугаарлаж, хадгаламжийн нэгжийг данс бүртгэлээр тавцангийн зүүн гар талаас дугаарын дарааллаар байрлуулж, тэдгээрийн байрлалыг харуулсан заагуур үйлдэн, сейф, тавиурын гадна талд байрлуулсан.

Мөн тус хэлтсээс ирүүлсэн албан бичгийн хүрээнд 2023,2024 оны цалингийн тооцооны хүснэгтийг цахим хэлбэрт шилжүүлэн, 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр хянуулан, алдааг засч, 2025 оны 06 дугаар сарын 11-ний өдөр хүлээлгэн өгсөн.

Архивын баримт тавих зориулалттай 2 ширхэг тавиур шинээр авсан ба 1 ширхэгийг нь агуулах, 1 ширхэгийг нь архивт угсарч, баримтыг байршуулсан.

Тайлант хугацаанд архиваас 29 удаа 110 хадгаламжийн нэгжийг албан хаагчдад түр ашиглуулахаар өгч, бүртгэл хөтлөн ажиллалаа.

Тайлант хугацаанд шийдвэрлэсэн лавлагааны хүсэлтийг 2024 оны мөн үетэй харьцуулбал 7,9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Д/д	Лавлагааны төрөл	Огноо		Үзүүлэлт	
		2024 оны хагас жил	2025 оны хагас жил		
1	Метадата	199	184	-15	-7,5%
2	Явуулсан	88	84	-4	-4,5%
3	Ирсэн	47	40	-7	-14,9%
4	Цахим	146	134	-12	-8,2%
Нийт		480	442	-38	-7,9%

ЭММЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Эрүүл мэндийн магадлалын салбар зөвлөлийн хурал долоо хоног бүрийн Лхагва гарагт Нийгмийн эрүүл мэндийг дэмжих төвд 80-100% ирцтэйгээр, өвчтөний баримт бичгийг үндэслэн нийт 18 удаа хуралдлаа. Хурлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, хэмжээг 32 иргэнд шинээр тогтоож, 20 иргэний ХЧА-ын хувь хэмжээг цуцалж, 3 шилжиж, 1 иргэн шилжин ирсэн байна. Энэ хугацаанд 210 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааны шийдвэрийг гаргасан бөгөөд энэ оны хагас жилийн байдлаар нийт 896 иргэн хөдөлмөрийн чадвар алдалттай байна.

Хөдөлмөрийн чадвар алдалтыг сэтгэцийн эмгэг, дотрын өвчин, мэдрэлийн эмгэг, нүд, гэмтлийн эмгэгүүд эхний 5 байр буюу нийт хөдөлмөрийн чадвар алдалтын 80 хувийг эзэлж байгаа ба хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн 70 гаруй хувь нь 31-59 насны хөдөлмөрийн насны иргэд байна.

Үйлдвэрлэлийн ослын шалтгаанаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон 24 хүн байна.

Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоолгосон 577 иргэн нийгмийн даатгалын сангаас, 319 иргэн нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авч байна. Хөдөлмөрийн чадвараа 50-69%-аар алдсан 460/51%, 70-100% алдсан 436/49% иргэн байна.

Шинэ хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалтыг хэрэгжүүлэн ажиллахад өмнөх хувь буурсан 10, хувь өссөн 14 иргэн байна. Шинээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, шалтгааныг тогтоолгож буй иргэний оношийг магадлах, биеийн байдлыг үнэлэх, мэдээлэл солилцох, эмчлэн эрүүлжих зөвлөгөө өгөх, цаашид зөв чиглүүлэх зэрэг асуудлаар

хуралд иргэнийг өөрийг нь байлгах шаардлагатай тул биеэр хуралд оролцуулан шийдвэрлэж байна.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой дүрэм, журмыг зөрчих, авлига, ашиг сонирхол, ёс зүйн аливаа алдаа дутагдал гарахаас урьдчилан сэргийлж ажилладаг.

- ✓ ЭММЗ-н хурал эхлэхээс өмнө хурлаар орох иргэдийн нэрсийн жагсаалтыг гишүүдэд танилцуулж, ашиг сонирхлын зөрчилтэй эсэх мэдүүлгийг амаар авч ашиг сонирхол үүссэн бол маягт бөглөн хурлын даргад танилцуулан шийдвэрлэн ажиллаж хэвшсэн. ЭММЗ-ийн орлогч даргын бэр эгч ХЧА-н хувь хугацааг шинээр шийдвэрлүүлэх хүсэлт гарсан тул орлогч дарга ашиг сонирхлын зөрчил мэдүүлэх маягт бөглөж, зөвлөлийн даргад мэдээллэсэн. Орлогч даргыг тухайн хүний ХЧА-н шийдвэрт оролцохгүйгээр шийдвэрлэн ажилласан бөгөөд мэдүүлэгийн маягтыг холбогдох иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын шийдвэрийн хуудсанд хавсаргав.
- ✓ ЭММЗ-ын хурлын үйл явцыг дүрс бичлэгт бичиж, цахим архив үүсгэн ажиллаж байна.
- ✓ Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс 2025 оны 05 сарын 28-ны өдөр Авилгатай тэмцэх газартай хамтран орон нутгийн Эрүүл мэндийн магадлах зөвлөлийн гишүүдэд Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулсан бөгөөд тус дүүргийн зөвлөлийн гишүүд цахимаар бүрэн хамрагдсан.

ЭМНЭЛГИЙН ХУУДАСНЫ ТАЛААР

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/177, А/433 хамтарсан тушаалаар шинэчлэн батлагдсан “Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам”-ыг баримтлан ажиллаж байна.

Тайлант оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар цахимаар 1509 эмнэлгийн хуудасны хүсэлт авч шийдвэрлэн ажилласан байна. Үүнд:

№	Цахим эмнэлгийн хуудасны төлөв	ХЧТА	ЖА	НИЙТ
1.	Шийдэгдсэн	1134	215	1349
2.	Цуцлагдсан	134	26	160
3.	Боловсруулж байгаа	0	0	0
	Нийт	1268	241	1509

Нийт 1509 эмнэлгийн хуудсыг хянан баталгаажуулсан бөгөөд эмнэлгийн хуудас олгох тухай журмаар 2 удаагийн сургалт хийж 56 эмч мэргэжилтнүүдийг хамруулсан.

ГУРАВ. ИРГЭДЭД ЭЭЛТЭЙ ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНГ БҮРДҮҮЛСЭН БАЙДАЛ

Үйлчилгээг илүү хүртээмжтэй хүргэх үүднээс хяналтын байцаагч нарын өрөөг сольж 1 давхарт шилжүүлэн, иргэдэд аль болох ойлгомжтой байдлаар өрөө тасалгааны зохион байгуулалтыг хийсэн.

Үйлчилгээний стандартыг сайжруулах ажлын хүрээнд Багануур дүүргийн Насан туршийн боловсролын төвөөс “Харилцаа, хандлага” сэдэвт сургалтад нийт 20 албан хаагчид оролцсон.

Callpro үмсаар мэдээлэл, зөвлөгөө хүргэх

Тус газар нь 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 12-ны өдөр хүртэлх хугацаанд нийт 3,333 дуудлага хүлээн авсан бөгөөд үүнээс 200 дуудлага алдагдсан байна. Нийт дуудлагын 6%-ийг хүлээн авч чадаагүй бөгөөд дуудлага алдалтын түвшин 10% дотор оруулж, төлөвлөсөн хэмжээнд ажилласан болно.



ДӨРӨВ. ДҮҮРГИЙН ТӨР ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН АЖЛЫН БИЕЛЭЛТ

НДЕГ-ын удирдах ажилтны зөвлөгөөн, Дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай хуралдаан 14 хоног тутамд зохион байгуулагддаг. Тус газрын удирдлага шуурхай хуралдаанд тогтмол оролцож, хуралдсан тухайн өдөрт багтаан бүх ажилтны хурал зарлаж, цаг үеийн мэдээллээр албан хаагчдыг тогтмол хангаж ажилладаг. Удирдах ажилтны шуурхай хуралдаанаар өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүр хэрэгжүүлж, тус газраас нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид орсон өөрчлөлт, цаг үеийн шинжтэй хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хүргэн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолоор Жил бүрийн 3 дугаар сарын 4 дэх долоо хоногийн Лхагва гарагт улсын хэмжээнд Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор аюулгүйн талбайд 13 хүн цугларч, 4 хүн сургалтад оролцож, цугларах нэгдсэн дадлага сургууль хийсэн илтгэх хуудсыг мэйл болон албан бичгээр илгээсэн.

Дүүргийн засаг даргын тамгын газар, Монгол улсын Ёс зүй хороотой хамтран хийсэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийн хэрэглээ, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын талаарх сургалтад нийт 18 албан хаагч оролцож 2025 оныг ёс зүйтэй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах зорилго тавин өөрсдийн зүгээс нийгмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, нийгмийн сайн сайхан зүйлсийн нэг хэсэг байна гэдэгтээ итгэлтэй байна.

ТАВ. БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГЫН МАНЛАЙЛАЛ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙДАЛ

Дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай хуралдаан 14 хоног тутамд зохион байгуулагддаг. Тус газрын удирдлага шуурхай хуралдаанд тогтмол оролцож, хуралдсан тухайн өдөрт багтаан бүх ажилтны хурал зарлаж, цаг үеийн мэдээллээр албан хаагчдыг тогтмол хангаж ажилладаг. Удирдах ажилтны шуурхай хуралдаанаар өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүр хэрэгжүүлж, тус газраас нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид орсон өөрчлөлт, цаг үеийн шинжтэй хэрэгжүүлэх арга хэмжээний талаар 1 удаагийн мэдээлэл хийсэн.



Тус газрын дарга Р.Өнөржаргал Удирдлагын академийн Төрийн албаны сургуулиас 2025 онд зохион байгуулсан Төрийн захиргааны ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдан амжилттай суралцаж, 2025 оны 06 дугаар сард сертификат гардан авлаа.

Тус газар нь Нийгмийн даатгалын байгууллагын 83 жилийн ойн хүрээнд Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газраас зохион байгуулсан Монгол бичгийн уралдаанд тус газрын Тэтгэврийн тогтоолт, олголтын байцаагч, мэргэжилтэн М.Мөнхчимэг тэргүүн байр, Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулсан Боулингийн тэмцээний гутгаар байранд тус тус шалгарсан.

Тус үйл ажиллагаанд 9 дүүргийн Нийгмийн даатгалын газрын 60 гаруй албан хаагч оролцсон.



Багануур дүүргийн Засаг даргын нэрэмжит “Хөдөлгөөн, эрүүл мэнд” сэдэвт биеийн тамир, спортын IX их наадам 2025 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдрийг дуусталх хугацаанд 85 байгууллага, аж ахуйн нэгжийн 16 баг тамирчдын дунд сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, дартс, шатар, 100 буудалт

даам, боулинг, коран хол, олс таталт, хөнгөн атлетик, ширээний шагай, спорт явган аяллын нийт 12 төрлөөр амжилттай зохиогдож өндөрлөлөө.

Тус наадамд дүүргийн ИТХ, ЗДТГ, түүний дэргэдэх газар, хэлтэс хамтарсан “Төрийн захиргаа” баг бүх төрөлд амжилттай оролцож тус газрын Г.Батболд, Т.Ганчимэг нар сагсан бөмбөг 40+ ангилалд, Г.Батболд волейболын төрөлд 40+ ангилалд, Б.Сүхболд хөнгөн атлетикийн 4x100м буухиа төрөлд, Б.Наранцэцэг ширээний шагайн 40+ ангилалд, Б.Балжинням эмэгтэй шатар төрөлд хамт олноо төлөөлөн өрсөлдөв.



Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагаас жил бүрийн 04 дүгээр сарын 28-ны өдрийг "Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэлхийн өдөр болгон тэмдэглэдэг бөгөөд Монгол Улсад жил бүр “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян” өрнүүлж аяны хүрээнд хууль тогтоомжийг сурталчлах, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажилтны эрүүл мэндийг хамгаалах, ажлын байрны соёлыг төлөвшүүлэх, сургалт сурталчилгаа хийх олон хэлбэрийн арга хэмжээг зохион байгуулсан.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн 2025 оны 04/1395 дугаар бичгийн хүрээнд Хүүхэд, залуучуудын хүмүүжлийн тусгай цогцолборт хүмүүжиж буй эгч дүү гурав хүүхдэд газрын хамт олноос 100,000 төгрөгийг хандивлав.

ЗУРГАА. САНХҮҮГИЙН ЗӨРЧИЛГҮЙ, ТӨСВИЙН ӨР АВЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар нь НББОУС, УСНББОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар IT zone ХХК-ийн “Green ERP” программ ашиглан бүртгэлийг хөтөлж, “Төсвийн тухай” хуулийн 54 дүгээр зүйлийн дагуу 2025 оны эхний улирлын санхүүгийн тайланг бэлтгэн, хуульд заасан хугацаанд, бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж, НДЕГ-т хүргүүлэв. Үүнээс гадна сар бүрийн мэдээг НДЕГ-т хүргүүлж, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллав.

Өдөр тутмын санхүүгийн гүйлгээг анхан шатны баримтад үндэслэн төрийн сангийн удирдлагын нэгдсэн систем <https://finance.gov.mn>, алба хаагчдын цалин хөлсийг төрийн албаны цалингийн нэгдсэн систем <https://payroll.gov.mn/> -ээр тооцож, НДШ, ХХОАТ, бусад төлбөр тооцоог тухай бүр гүйцэтгэж, холбогдох портал сайтаар тайлангийн мэдээллийг оруулан, зохих газруудад илгээв.

Тус газрын өглөг, авлагыг баталгаажуулж, хамтран ажилласан гэрээт байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн 2025 оны 02 дугаар улирлын санхүүгийн тайлан гаргахад бэлтгэж байна.

Мэдээллийн ил тод байдал, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагааны төсөв, зардалтай холбоотой 28 төрлийн 68 мэдээг <https://info.shilendans.gov.mn/> цахим хуудаст байршуулж, мэдээлсэн. Тайлант хугацаанд хугацаа болоогүй 103 мэдээ хүлээгдэж байна.

Шилэн дансны цахим системд бүх мэдээг цаг тухайд нь мэдээлж, “Ил тод, нээлттэй байдал, шилэн дансны мэдээллийн самбар”-т байршуулсан хэдий ч 2 төрлийн мэдээг хуулиар тогтоосон хугацааны дараа засварласанаар хугацаа хэтэрсэн төлөвт шилжсэн.

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх заалтын дагуу 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд “Гэрэлт Хөхийн Тэнцвэрт Аудит” ХХК-ийн гүйцэтгэсэн аудитаар тус газар “Өөрчлөлтгүй” дүгнүүлсэн.

Дээрх аудитаар өгсөн зөвлөмжийн хүрээнд 3388,0 мянган төгрөгийн өртөг бүхий аж ахуйн бүх ажил гүйлгээг бараа материалын орлого, зарлагаар бүртгэн, 2809,1 мянган төгрөгийн өртөг бүхий өглөгийн үлдэгдэлийг харилцагч байгууллага тус бүрээр тооцоо нийлж баталгаажуулсан акт үйлдсэн.

Аудитын шалгалтаар өгөгдсөн 2 зөвлөмжийн биелэлтийг хангаж ажилласан тухай 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр хариуг хүргүүлсэн.

1. Орлогын талаар:

Үйл ажиллагааны зардлын 2025 оны 966,724.4 мянган төгрөгийн жилийн батлагдсан төсвөөс, төсвийн хуваарийн дагуу тайлант оны эхний хагас жилийн үйл ажиллагааны урсгал санхүүжилт 390,402.2 мянган төгрөг авахаас 355,886.7 мянган төгрөгийг авч санхүүжилтийн орлого 91,15 хувийн гүйцэтгэлтэй байна. Хөдөө орон нутагт тогтвор суурьшил

тай ажиллсан албан хаагчид олгодог 5 жилийн урамшуулалын санхүүжилт 2025 оны 4 дүгээр сард орох байсан боловч санхүүжилтийн эрхийн хүсэлтийг 4 болон 5 дугаар сард сангийн яамнаас хүлээж аваагүйтэй холбоотой тус санхүүжилт ороогүй.

2. Зарлагын талаар:

Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдлөг болгон 2025 оны эхний хагас жилд үйл ажиллагаанд 355,886.5 мянган төгрөгний зардал гаргасан нь нийт орж ирсэн төсвийн 99,99 хувийг эзэлж байна. Үүнээс 42528.6 мянган төгрөг буюу нийт санхүүжилтийн 13,57 хувийг Сангийн яамнаас улсын төсөвт буцааж татан төвлөрүүлсэн.

Тайлант хугацааны туршид зардлын бүлэг дотор төсвийг хэтрэлтгүйгээр зарцуулахад анхааран ажиллаж, 2025 оны 06 дугаар сарын 2 дугаар хагасын цалин, татвар, бусад ажил гүйлгээ хийгдэх хугацаа болоогүй тул 87 сая төгрөгийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна.

3. Бараа материал, үнэт цаасны талаар:

Тайлант хугацаанд 28092.9 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна. Хангамжийн бараа материалыг батлагдсан төсвийн хүрээнд сар бүр татан авч зохих нөөц бүрдүүлэн ажиллаж байна. Баталгаажсан шаардах хуудсаар зарлага бүртгэж, зарцуулалтыг сар бүр бараа материалын тайланд тусгаж хэвшсэн.

4. Үндсэн хөрөнгийн талаар:

2025 оны 01 дүгээр улирлын байдлаар нийт эргэлтийн бус хөрөнгө 585,083.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байна.

Үүнээс:

1. Барилга, байгууламж	494,095.3	мян.төгрөг	/2006 онд ашиглалтад орсон./		
2. Авто машин	3,259.6	мян.төгрөг			
3. Машин, тоног төхөөрөмж	35,308.6	мян.төгрөг			
4. Тавилга эд хогшил	21,719.4	мян.төгрөг			
5. Биет бус хөрөнгө /газар/	30 700.0	мян.төгрөгийн	хөрөнгө	илүүдэл	

дутагдалгүй, бүрэн бүтэн ашиглагдаж байна.

2024 оны өмчийн хөдлөл өөрчлөлтийн тайланг <https://umch.sgov.mn/> төрийн өмчийн тооллогын системд 2025 оны 04 сарын 15-ны дотор илгээлээ.

Тайлант оны 04 дүгээр сард ТӨБЗГ-аас тус газрын төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийв.

Шалгалтаар барилга байгууламжийн ашиглалтын дүрэм, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг нормд заасны дагуу барилга байгууламжийн эдэлгээний хугацаанд үзлэг шалгалтыг хийж хувийн хэрэгт тэмдэглэгээ бүрэн хийгдсэн, авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын хувийн хэрэгт татвар, тос маслоны мэдээллийг бөглөсөн, Өмч хамгаалах байнгын зөвлөл зохих ёсоор ажилласан тухай тайланд дурдсан байна.

Харин НДЕГ-аас балансаас балансад шилжиж ирсэн 11 нэр төрлийн 16.34 сая төгрөгийн хөрөнгөнөөс нийт 9.91 сая төгрөгийн дүнтэй 4 компьютерын процессор, хулгана дутуу ирсэн бол 2.45 сая төгрөгийн дүнтэй 1 компьютер иж бүрдлээр БНД НДГазарт

хүлээлгэж өгөөгүй зөрчил илэрсэн. Шалгалтын хугацаанд 4 компьютерын дутуу ирсэн процессор хулганыг холбогдох байгууллагаас хүлээн авч зөрчлийг арилгасан.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Эрх бүхий байгууллагаас баталсан хөрөнгө хуваарилсан жагсаалтын дагуу ирсэн хөрөнгийг хүлээн авч, тооцоо нийлсэн акт үйлдэж хэвших, НДЕГ-аас 2.45 сая төгрөгийн дүнтэй 1 ширхэг компьютерыг балансаас балансад хүлээн авч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2024 оны А-1/2456 албан бичгийн шийдвэрийн хэрэгжилтийн хангаж ажиллахыг үүрэг болгов.

5. Өр, авлагын талаар

2025 оны эхний хагас жилд өр авлагагүй ажиллах зорилт дэвшүүлсэн боловч 2025 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ажилчидтай холбоотой өглөг 33,993.5 мянган төгрөгт хүрээд байна.

Энэ нь шинээр нэвтрүүлж буй цахим систем Sicos программд 2024 оны ажлыг нөхөн оруулж, тайлан гаргахад илүү цагаар ажиллах, түүнчлэн зэргийн нэмэгдэл болон мэргэшлийн зэргийн нэмэгдлийг тооцон олгосонтой холбоотой өр үүссэн ба тухайн жилд цалин, шимтгэлд 42,580.0 мянган төгрөгийн нэмэлт эх үүсвэр шаардлагатай тул судалгааг гаргаж НДЕГ-ын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газарт хүсэлт гаргав.

2025 онд Харуул хамгаалалтын зардалд нийт 720.0 мянган төгрөг, тээврийн хэрэгслийн татвар болон газрын төлбөрт 174.1 мянган төгрөг тус тус дутагдаж байгаа бөгөөд хэмнэгдэж байгаа зардлын ангиллаас шилжүүлэх хүсэлт өгсөн боловч сангийн яамнаас төсөв хойшлуулан татсантай холбоотой холбогдох газраас хариу ирүүлээгүй байна.

Тус газрын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлангаар тайлант хугацааны өглөг, авлагыг баталгаажуулж хамтран ажилласан гэрээт байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэхээр холбогдох ажил гүйлгээг бэлтгэж байна.

6. Орон тоо, цалингийн талаар:

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны Газар зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай А/12 тоот тушаалын хавсралтад зааснаар Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын орон тоо Удирдах-4, Гүйцэтгэх-14, үйлчлэх-2 /ТЗ-13, ТҮМ-4, ТҮ-3/ нийт 20 батлагдсанаас тайлант хугацаанд 20 орон тоогоор ажилласан.

Эрүүл мэндийн магадлалын зөвлөл, Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн гишүүдэд 2025 оны 01-03 дугаар сарыг дуустал нэг цагийн 15716 төгрөг, 04 дүгээр сараас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой нэг цагийн 18860 төгрөгөөр хурлын ирцийн цаг бүртгэлийг үндэслэн мөнгөн урамшууллыг тооцож, сар бүр батлагдсан төсвөөс олгож, нийгмийн даатгалын болон татварын тайланг хуулийн хугацаанд илгээж байна.

6. Өр, авлагын талаар

2024 оны эхний хагас жилд өр авлагагүй ажиллах зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Хууль журмын хэрэгжилтийн хүрээнд төрийн алба хаагчийн үндсэн цалинг 10 хувиар, орон нутагт ажилласан нэмэгдэл 20 хувиар нэмэгдэж, байгууллагын бүтэц шинэчилэгдсэнээр удирдах ажилтны цалингийн шатлал өөрчлөгдсөнтэй холбоотой цалин, шимтгэлд 101,9 сая төгрөгийн нэмэлт эх үүсвэр шаардлагатай тул судалгааг гаргаж, дээд шатны байгууллагад мэдэгдсэн.

Тайлант хугацаанд дээрх шалтгаанаар цалин, шимтгэлийн зардал 4,1 сая төгрөгөөр дутаж өр үүссэн тухай Бодлогын хэрэгжилт, судалгааны газарт уламжлаад байна.

Тус газрын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлангаар тайлант хугацааны өглөг, авлагыг баталгаажуулж хамтран ажилладаг гэрээт байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэхээр холбогдох ажил гүйлгээг бэлтгэж байна.

Эд хөрөнгийн хадгалалт хамгаалалтын талаар:

Өмч хамгаалах комиссын гишүүд төрийн өмчийн программд байгууллагад бүртгэлтэй үндсэн хөрөнгийн бүртгэлийг шивж оруулсантай холбогдуулан албан хаагчийн эд хөрөнгийн картад өөрчлөлт оруулах шаардлагатай болсон тул 2025 оны хагас жилийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогоос өмнө бэлэн болгох зорилготой байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай 49 төрлийн 3297 ширхэг 2,720,270 төгрөгийн эд материалын худалдан авалт хийж, 141 нэр төрлийн 2897 ширхэг 4,039,216.50 төгрөгийн материалыг албан хаагчдын албаны хэрэгцээнд өгч, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны материалыг бүрдүүлж, тайланг сар бүр хугацаанд нь гарган ажилласан.

ДОЛОО. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭР, ТАЙЛАН МЭДЭЭНИЙ ЧАНАР, ХУГАЦАА

- ✓ **Дээд газрын ирүүлсэн тогтоол, шийдвэрийг бүртгэж, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах**

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд эрх зүйн шинэчлэлтийг цахим системд зүгшрүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж ажиллав.

- ✓ 2025 оны эхний хагас жилийн байдлаар дээд газраас ирүүлсэн 25 эрх зүйн актыг хэрэгжүүлэн ажиллав.

Ирүүлсэн шийдвэрийг төрлөөр нь авч үзвэл:

№	Эрх зүйн актын нэр	Тоо
1.	Монгол Улсын хууль	3
2.	Засгийн газрын тогтоол	4
3.	ХНТ-ийн Гурван талт үндэсний хорооны тогтоол	1
4.	НДҮЗ-ийн тогтоол	3
5.	ЭМ-ийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол	1
6.	НДЕГ-ын даргын тушаал	12
7.	НДЕГ-ын даргын албан даалгавар	1
Нийт		25


- ✓ **Үйлчилгээ, өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлт, хяналт**

Нийгмийн даатгалын байгууллагаас үйлчилгээ авахаар иргэд, даатгуулагчдын ирүүлсэн хүсэлтийг өргөдөл, гомдлын дэвтэрт бүртгэж, бүртгэл хяналтын карт хөтлөн, холбогдох албан тушаалтанд шилжүүлж, явц, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд нийт 829 хүсэлт бүртгэгдсэнээс 93,4%-ийг шийдвэрлэж ажиллав. Тэтгэвэр тогтоолгох цалингийн 2025 оны итгэлцүүр өөрчлөн батлагдсантай холбоотой Sicos программд өөрчлөлт хийх ажил хүлээгдсэнээс шалтгаалан 2025 оны 01 дүгээр сарын шинэ тэтгэврийн тогтоолт, олгох ажлууд удааширч 53 өргөдөл, 2024 оны жилийн эцсийн тайлан гаргахтай холбоотой сайн дурын даатгалын 4 өргөдөл хугацаа хэтэрч шийдэгдсэн бол тэтгэмжийн байцаагч албан ажлын шаардлагаар 2025.02, 03 дугаар сард үйл ажиллагааны нябо-г хавсарч ажилласан хугацаанд Төрийн өмчийн программд үндсэн хөрөнгийн мэдээлэл шивж, тайлан гаргах, НДЕГ-аас шалгалт ирсэн үеийн ажлын ачаалал огцом өссөнөөс тэтгэмжийн 49 өргөдөл тус тус хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн байна.

Нийгмийн даатгалын цогц системийг хөгжүүлж, нэвтрүүлэх ажлаас шалтгаалан зарим даатгуулагчдын тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь тогтоох, олгох ажлууд удааширснаас үүдэн 11-11 төвд 6 гомдол бүртгэгдсэнийг тухай бүр судлан шийдвэрлэж, иргэдэд хариу хүргүүлж ажилласан.

Тус газраас иргэд, даатгуулагчдад хүргэсэн үйлчилгээ, тус газарт хандсан гомдлыг сүүлийн 3 жилийн мөн үеэр харьцуулан харуулбал:



2025 оны 1 дүгээр улирлын өргөдөл, гомдлын тайланг гаргаж, 2025 оны 03 дугаар сарын 14-ны өдөр НДЕГ-т хүргүүлсэн.

✓ **Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа**

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, Баримт бичгийн стандарт (MNS5140:2021-1, 2, 3), Засгийн газрын 2025 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан “Журам батлах тухай”, Монгол хэлний тухай хуулийн 7.2. дах хэсэгт заасны дагуу үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна, 11.1.2.монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах, хөгжүүлэх, үндэсний бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжих дунд болон урт хугацааны үндэсний хөтөлбөр, дүрэм, журам, үндсэн чиглэл боловсруулж хэрэгжүүлэх гэсэн заалтын дагуу архив, албан хэрэг хөтлөлтөө хөтөлж байна.



2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс архив, албан хэрэг хөтлөлтөө хос бичгээр хөтлөнө гэсний дагуу монгол бичгийн 4 төрлийн хэвлэмэл хуудасны загварыг шинэчлэн Нийслэлийн архивын газарт захиалга өгч, хэвлүүлсэн.

Албан хэрэг хөтлөлтийн edoc дэд системээр нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудтай, able программаар Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймгийн Нийгмийн даатгалын газартай албан бичиг солилцон ажиллаж байна.

Цаасаар ирүүлсэн 101 албан бичгийг edoc.ulaanbaatar.mn системд бүртгэж, гадагш илгээсэн 115 албан бичгийг системээр боловсруулав.

Тус газраас гадагш илгээж буй албан бичгийг edoc системийн баримт боловсруулалт цэсээр боловсруулах ажлыг хэвшүүлж, тоон гарын үсгээр баталгаажуулан илгээж, үндэсний бичгээр хөрвүүлж, байгууллагад үлдэх хувийг хэвлэмэл хуудсанд буулган архив, албан хэрэг хөтлөлтийн журам, стандартыг мөрдөн ажиллалаа.

✓ **Авлига гэмт хэргээс, урьдчилан сэргийлэх чиглэлээр**

Тус газрын албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөн ажиллаж байгаа ба тайлант хугацаанд ёс зүй, харилцаа хандлага, сахилга хариуцлагатай холбоотой зөрчил гаргасан албан хаагч байхгүй болно.

Авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор 3 зорилт 17 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг 90%-иар ханган ажиллав.

Өмнөх жил буюу 2024 оны ХАСХОМ-ийг 7 албан хаагч 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдөрт багтаан мэдүүлж, тайланг хуулийн хугацаанд НДЕГ-т хүргүүлэв.

Тайлант оны эхний хагас жилийн байдлаар шинээр ажилд томилогдсон 2, шилжиж явсан 1, шилжиж ирсэн 1, чөлөөлөгдсөн 2, нийт 7 албан хаагчийн өөрчлөлт хөдөлгөөн гарсан. Шинээр томилогдсон 2 албан хаагч ХАСУМ, ХАСХОМ мэдүүлэхгүй, шилжүүлэн томилогдсон албан хаагч нь ТЗ-7 зэрэглэлээс ТЗ-8 зэрэглэлд буурч шилжсэн тул ХАСУМ, ХАСХОМ мэдүүлээгүй болно.

АТГ-аас зохион байгуулсан 2 удаагийн сургалтад ЭБАТ оролцож, мэдээлэл авч түгээлээ. Үүнээс гадна хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 250 дахин нэмэгдүүлсэнээс дээш их хэмжээний өөрчлөлт орсон бол 30 хоногийн дотор мэдээлэх гэсний дагуу нийт албан хаагчдад, түүний дундаас ХАСХОМ гаргагч нарт онцлон сануулж, хууль хэрэгжүүлж ажиллахыг зөвлөв.

Мөн газраас зохион байгуулсан сургалтад магадлагч эмч, эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд нийт 10 хүн оролцож мэдлэг, ур чадвараа дээшлүүлэв.

Хүний нөөцийн чиглэлээр

Тус газар нь 2025 оны эхний 5 сарын байдлаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан зохион байгуулалтын 3 хэлтэс, удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 17, үйлчлэх 2 нийт 20 албан хаагчтайгаар ажиллаж байна.

Хүний нөөцийн үзүүлэлтийг боловсролын зэрэг, гендер, насны ангилал, салбарт ажилласан хугацаагаар ангилан харуулбал дараах байдалтай байна.



Боловсролын

зэрэг: Магистр 25%
Бакалавр 65%
Бүрэн дунд 10%



Гендер

Эрэгтэй 20%
Эмэгтэй 80%



Салбарт ажилласан

жил:
5 хүртэл жил 55%
5-9 жил 25%
10-14 жил 20%
15-аас дээш жил 5%



Насны ангилал:

25-34 нас 35%
35-44 нас 30%
45-54 нас 30%
55-59 нас 5%

Тайлант хугацаанд орон тооны хэтрэлтгүй ажиллаж, хүний нөөцийн шилжилт хөдөлгөөний 6 удаагийн мэдээг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн.

2025 оны эхний хагас жилийн байдлаар хүүхдээ асарч байгаа албан хаагч 1, шинээр ажилд томилогдсон 2, шилжиж явсан 1, шилжиж ирсэн 1, чөлөөлөгдсөн 2, нийт 7 албан хаагчийн өөрчлөлт хөдөлгөөнийг холбогдох программд бүртгэсэн.

Ажлын бүтэн бус цагаар ажиллах гэрээгээр 1 ажилтныг ажиллуулж байна. Албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөр батлуулж ХНУМТ программд оруулсан.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, ажил-ар гэрийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор хэлтсийн даргын 2019 оны А/31 дүгээр тушаалаар 16 хүртэлх насны хүүхдийн төрсөн өдрөөр ажилтанд цалинтай чөлөө олгох шийдвэрийн дагуу 3 албан хаагчид цалинтай чөлөө олгов.

Тайлант хугацаанд хүний нөөцтэй холбоотой 14 төрлийн судалгааг гарган холбогдох байгууллагад хүргүүлээ.

Хүний нөөцийн нэгдсэн системүүдэд албан хаагчдын мэдээллийг бүртгэн, шаардлагатай тохиолдолд мэдээллийг шинэчлэн, өөрчлөлт оруулж ажиллав. Тус газрын нийт албан хаагчдын мэдээлэлд төрийн албан хаагчийн шинэчлэгдсэн цалин, даатгуулагчийн төрлийн 5 оронтой код, ажил мэргэжлийн ангиллын кодыг өөрчилж, зарим албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, зэрэг дэвийн, мэргэшлийн зэргийн нэмэгдлийн хувь хэмжээг тухай бүр шинэчлэн бүртгэлээ.

Хуулийн мэргэжилтэний хэрэгжүүлсэн ажлын талаар

Нийгмийн даатгалын байгууллага 2025 оныг “Даатгуулагчийг дэмжих, Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах” жил болгон зарласан.

Нэрэмжит жилд шимтгэлийн өр авлагыг бууруулах ажлын хүрээнд НДЕГ-ын даргын 2025 оны 04 дүгээр сарын А/103 дугаар “Нийгмийн даатгалын байгууллагад холбогдох гүйцэтгэх баримт бичгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эрчимжүүлэх хамтын ажиллагааны санамж бичиг”-ийн хүрээнд нийт 6 албан байгууллагыг иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлж нийт 1,049 сая төгрөгийн авлагаас 214,0 сая төгрөгийг барагдуулахаар, 624.3 сая төгрөгийн алдангиас 24.4 сая төгрөгийг төлүүлэхээр шүүхээр шийдвэрлүүлж, Монцахим ХХК-ийн шүүхийн шатанд НДЕГ-т гаргасан 199.5 сая төгрөгийн алдангиас чөлөөлүүлэх хүсэлтийг үндэслэж дээд газраас ирүүлсэн чиглэлийн дагуу 199.5 сая төгрөгийн алдангийг чөлөөлж эвлэрэлийн гэрээ байгуулсан.

Багануур дүүргийн ШШГХ-ийн хамт олонтой 2025 оны эхний хагас жилд 1 удаа уулзалт хийж НДЕГ-аас ШШГБ-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд МИМС ХХК-ийн судалгааг Шимтгэл хураалтын удирдлага, арга зүйн газарт хүргүүлсэн.

Газрын даргын А тушаал 24, Б тушаал 25 нийт 49 тушаалын хуулийн ишлэлийг хянаж, 10 албан бичгийг боловсруулж, хууль, эрхзүйн чиглэлээр ирүүлсэн 2 судалгааг гаргав.

Маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөлийн ажил

Тус зөвлөл нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, ажил олгогч, даатгуулагчийн болон нийгмийн даатгалын байгууллагын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх, ажил олгогч, даатгуулагчийн нууцыг чанд хадгалах зарчмыг баримталж, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрмийг удирдлага болгон ажиллаж байна.

Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн гишүүдийн албан тушаалын нэршил өөрчилсөнтэй холбоотойгоор тус газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 27-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар салбар зөвлөлийн даргаар тус газрын дарга, гишүүдээр санхүү бүртгэл, хамралт, орлогын хэлтсийн дарга, тэтгэвэр, тэтгэмжийн хэлтсийн дарга, захиргаа, хяналтын хэлтсийн дарга, орлого шимтгэлийн байцаагч, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга болон нийгмийн хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн нар, дүүргийн Ажил олгогч эздийн холбооны тэргүүлэгч гишүүн, Багануур ХК-ийн хуулийн зөвлөх, нарийн бичгийн даргаар тус газрын хяналт шалгалтын байцаагч нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй шинэчилсэн бүрэлдэхүүнийг баталсан байна.

Тайлант хугацаанд салбар зөвлөл нь 3 удаагийн хурлаар тэтгэвэр тогтоолгох зорилгоор хөдөлмөрийн хортой нөхцөлөөр 1, хүнд нөхцөлөөр 1, өөрчлөн тогтоосон

тэтгэвэрийн олгож эхлэх хугацааг тогтоолгох 2, нийт 4 даатгуулагчийн өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, 3 даатгуулагчийн хүсэлтийг ханган шийдвэрлэж, 1 даатгуулагчийг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласнаар тооцох боломжгүй талаар шийдвэрлэсэн байна.

Зөвлөлийн гишүүдэд хурлын өмнө хүсэлт гаргасан иргэдийн нэрсийг танилцуулж, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл бөглөж хэвшсэн.

Хүсэлт, шийдвэрлэлтийн агуулгыг хүснэгтээр харуулбал:

Өргөдлийн төрөл	Өргөдлийн тоо	Хэрхэн шийдвэрлэсэн
Хөдөлмөрийн хортой нөхцөлөөр ӨНТ тогтоон олгох боломжгүй тухай	1	Хөдөлмөр, нийгмийн хамгаалын сайдын 2023 оны А/221 дугаар тушаалаар баталсан “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-ын “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой халуун хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалт”-ын - Хоёр. “Хөдөлмөрийн хортой нөхцөл”-ийн 2.19 дэх хэсгийн “Нефть боловсруулах үйлдвэр”-ийн 200 дахь заалтын 9333-15 кодтой шатахуун ачигч, шатахуун буулгагч ажлын байрт дүйцүүлж, хөдөлмөрийн хортой нөхцөлд хамааруулан тооцохгүй болохыг тогтоосон.
Хүнд нөхцөлөөр ӨНТ тогтоолгох тухай	1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/221 дугаар тушаалаар баталсан “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтыг хэрэглэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.7 дахь хэсэг заасан жишээ-2 баримтлан Дөрөв. “Хөдөлмөрийн хүнд нөхцөл”-ийн 31 дэх хэсгийн “Нийслэлийн нийтийн тээврийн том оврын зорчигч тээвэр”-ийн 1-т заасан 8331-11 кодтой ажил, мэргэжилд хамааруулан хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажилласнаар тооцсон.
Тэтгэвэр олгож эхлэх хугацааг тогтоох тухай	2	Цэргийн алба хаасны тэтгэврийг өөрчлөн тогтоолгох зорилгоор, 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр тус газарт тэтгэвэр тогтоолгосон хугацаанд хамаарах 2005 оны 02, 03 дугаар сарын цалинг залруулах хүсэлт ирүүлсэнийг харгалзан, өмнө авч байсан тэтгэвэр, өөрчлөн тогтоосон тэтгэврийн зөрүүг тооцож, 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс нөхөн олгох. Өндөр насны тэтгэврийг өөрчлөн тогтоолгох зорилгоор тэтгэвэр тогтоолгосон хугацаанд хамаарах 1995 оны 12 сар, 1998 оны 7, 9, 11, 12 сар, 2000 оны 12 сар, 2001 оны 1, 3, 4-10 дугаар саруудын цалинг нөхөн төлүүлэх хүсэлтийг 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр тус газарт ирүүлснийг харгалзан өмнө авч байсан тэтгэвэр, өөрчлөн тогтоосон тэтгэврийн зөрүүг тооцож, 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс нөхөн олгох.

НАЙМ. ДҮҮРЭГ БОЛОН БАЙГУУЛЛАГА ОРЧНОО ТОХИЖУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖИЛ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 62 дугаар зарлигаар “Жил бүрийн 5, 10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн “Бямба” гарагийг бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” болгон зарласан.

Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-т Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 08/525 дугаар албан бичгээр ирүүлсэн дүүргийн арга хэмжээнд зориулан Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасны дагуу мөнгөн хандивыг 1 ажилтны 10000 төгрөгөөр тооцож нийт 20 ажилтны 200000 төгрөгийг Төрийн сан банкны 100200255204 тоот дансанд төвлөрүүлэн байгууллага, дүүрэг орчноо тохижуулах ажилд мөнгөн хандив өргөж хувь, нэмэр оруулав.

Тус газар нь өөрийн эзэмшлийн талбайд 2012 оноос эхлэн жил бүр нэмж, нөхөн тарилт хийсэн монос, улиас, шинэс, модлог хуайс, шар хуайс, гүйлс, буйлс, голт бор, гацуур, далийн ягаан, нохойн хошуу, тавилгана зэрэг 12 төрлийн 400 орчим, ойр орчмын нийтийн эзэмшлийн талбайд агч, хайлаасын 2 төрлийн 30 ширхэг модыг тарьж ургуулан, усалгаа, арчилгааг жил бүр тогтмол хийж байна.

Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсээс ирүүлсэн албан бичгийн дагуу бүх нийтээр цас, хог цэвэрлэх 13 удаагийн үйл ажиллагаанд оролцож, өөрийн болон нийтийн эзэмшлийн зам, талбайн цас, ногоон бүс, хотын төвийн хуваарьт талбай, хэлтсийн хашааны дотор, гадна эргэн тойрны шар өвс, хогийг цэвэрлэх, цонх, хашаа, хайс, албан тасалгааны орчныг угаах ажлыг гүйцэтгэсэн.

ЕС. АЖИЛТНУУДЫН АЖИЛЛАХ ОРЧИН НӨХЦӨЛ, НИЙГМИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2023 оны А/11 дүгээр тушаалаар “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн тайланг 2025 оны 06 дугаар сарын 10-нд Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлээ.

Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 20 албан хаагчийн үндсэн цалингийн хэмжээг 6% нэмэгдүүлсэн.

Ар гэрт нь гачигдал гарсан 2 албан хаагчид хэлтсийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу 600,000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон.

ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан газрын албан хаагчдын 0-16 насны 29 хүүхдэд нийгмийн даатгалын байгууллагын ажлын онцлогийг таниулан сурталчлах “Хүүхэд бүр уншигч” сэдэвт өдөрлөг зохиож 850,000 төгрөгийг зарцуулав.

Газрын даргын 2025 оны А/09 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг албан хаагчдын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авч, үр дүнд үндэслэн шаардлагатай зөвлөгөө, мэдээлэл өгөв.

АРАВ. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ, ҮР ДҮН

✓ Авлига гэмт хэргээс, урьдчилан сэргийлэх чиглэлээр

Тус газрын албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөн ажиллаж байгаа ба тайлант хугацаанд ёс зүй, харилцаа хандлага, сахилга хариуцлагатай холбоотой зөрчил гаргасан албан хаагч байхгүй болно.

Авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор 3 зорилт 17 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг 90%-иар ханган ажилласан тухай тайлан 2025 оны 06 дугаар сард НДЕГ, дүүргийн ЗДТГ-т хүргүүлэв.

Өмнөх жил буюу 2024 оны ХАСХОМ-ийг 7 албан хаагч 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдөрт багтаан мэдүүлж, тайланг хуулийн хугацаанд НДЕГ-т хүргүүлэв.

Тайлант оны эхний хагас жилийн байдлаар шинээр ажилд томилогдсон 2, шилжиж явсан 1, шилжиж ирсэн 1, чөлөөлөгдсөн 2, нийт 7 албан хаагчийн өөрчлөлт хөдөлгөөн гарсан. Шинээр томилогдсон 2 албан хаагч ХАСУМ, ХАСХОМ мэдүүлэхгүй, шилжүүлэн томилогдсон албан хаагч нь ТЗ-7 зэрэглэлээс ТЗ-8 зэрэглэлд буурч шилжсэн тул ХАСУМ, ХАСХОМ мэдүүлээгүй болно.

АТГ-аас зохион байгуулсан 2 удаагийн сургалтад ЭБАТ оролцож, мэдээлэл авч түгээлээ. Үүнээс гадна хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 250 дахин нэмэгдүүлсэнээс дээш их хэмжээний өөрчлөлт орсон бол 30 хоногийн дотор мэдээлэх гэсний дагуу нийт албан хаагчдад, түүний дундаас ХАСХОМ гаргагч нарт онцлон сануулж, хууль хэрэгжүүлж ажиллахыг зөвлөв.

Мөн газраас зохион байгуулсан сургалтад магадлагч эмч, эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд нийт 10 хүн оролцож мэдлэг, ур чадвараа дээшлүүлэв.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай



**ШИЛ
АЖИЛЛАГАА**
shilen.gov.mn

Тус газар нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 03/3358 дугаар албан бичгийн хавсралтаар ирүүлсэн Нээлттэй мэдээллийн “SHILEN.GOV.MN” цахим системд нийтэлсэн 1 дүгээр улирлын тайлангийн үнэлгээгээр Чиг үүрэг үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 70%, Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 83%, Төсөв санхүү худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 83%, Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 73%, Бусад мэдээллийн ил тод нээлттэй байдал 41%, нийт үнэлгээ 74 хувьтай байна.

**АРВАН НЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ИРГЭД, ДААТГУУЛАГЧДАД СУРТАЛЧИЛСАН
БАЙДАЛ, ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА, ҮР ДҮН**

Тайлант хугацаанд хэрэгжүүлэх сургалт сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, мөн Захиргаа, хяналтын хэлтсийн төлөвлөгөөнд сургалт сурталчилгааны чиглэлээр хийх ажлуудыг тусгаж газрын даргаар батлуулан, мөрдөж хэрэгжилтийг ханган ажиллав.

Цахим сүртэлчилгаа



 Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар нь олон нийтийг Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллээр хангах, сурталчлах зорилгоор 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 12-ны өдрийн хооронд албан ёсны Facebook хуудсаар нийт 327 нийтлэл байршуулсан. Эдгээр нийтлэл нийт 25,398 хандалт, 200 хариу үйлдэл, 30 сэтгэгдэл, 271 хуваалцал авсан байна. Мөн тус газрын зүгээс бэлтгэсэн 10 постер, 1 ширхэг Рийлс/видео контент, “Багануурын мэдээ” веб сайтаар дамжуулсан 2 нийтлэл олон нийтэд хүргэгдсэн ба фэйсбүүк хуудас 4130 дагагчтай болсон. Үүнээс гадна Нийгмийн даатгалын ерөнхий газрын Facebook хуудас болон Instagram хаягийн хандалтыг нэмэгдүүлэх зорилгоор тус газрын нийт албан хаагчид тухайн хуудсуудыг дагаж, идэвхтэй оролцсон.



Ажил олгогч, даатгуулагчид чиглэсэн сургалт, сурталчилгаа

Нийгмийн даатгалын тухай шинэчилсэн хууль тогтоомж, шинэчлэгдсэн программ хангамж болон цахим үйлчилгээний талаарх мэдээлэл, зөвлөгөө хүргэх зорилгоор ЗХХ-ийн дарга Г.Батболд “Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга”, “Нийгмийн даатгалын шинэчлэлийн асуудлууд” сэдвийн хүрээнд нийт 13 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулсан бол ахлах нягтлан бодогч Ц.Солонготой хамтран арилжааны банктай хамтран ажиллах гэрээний дагуу 4 удаагийн сургалтад мэдээлэл хүргэсэн. Эдгээр сургалтад ажил олгогч байгууллагуудын удирдах ажилтан, нягтлан бодогч зэрэг 315 даатгуулагч, иргэнийг хамруулав.






Ажилтан, албан хаагчдад зориулсан сургалт




Албан хаагчдын мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх хүрээнд сургалтын хэрэгцээг тодорхойлж, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан батлуулав. Үүний дагуу мэргэжлийн болон бусад сэдвээр чадавхжуулах, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх 39 удаагийн сургалтад давхардсан тоогоор 179 албан хаагчийг танхим болон цахимаар хамруулав.





Бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан ажилтан Багануур дүүргийн Насан туршийн суралцахуйн төвөөс зохион байгуулсан Монгол бичгийн анхан болон дунд шатны сургалтад хамрагдаж, батламж авсан.



Захиргаа, хяналтын хэлтсийн дарга Жендэрийн үндэсний хорооны Удирдах албан тушаалтанд зориулсан жендэрийн цахим сургалтыг судлан суралцаж, амжилттай шалгуулсанаар Ж-1 гэрчилгээ авлаа.

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Г.БАТБОЛД

ТАЙЛАН БИЧСЭН:
ХҮНИЙ НӨӨЦ,
ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

А.УНДАРМАА